



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН 2023 ОНЫ IV УЛИРЛЫН БАЙДЛААР ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

Тус хэлтэс нь Нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах, үйлчилгээний стандарт, чанар хүртээмж, үйлчилгээний соёл, сахилга хариуцлага, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын үр дүнг дээшлүүлэх, байцаагч ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хариуцлагыг чангатгах, иргэдийг нийгмийн даатгалд даатгах, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай түргэн шуурхай хүргэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангахад анхаарч тодорхой ажлуудыг төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын бүтэц орон тоо баталсан 2018 оны А/22 дугаар тушаалын дагуу Орлого шимтгэлийн тасаг, Санхүү бүртгэлийн тасаг, Хяналт, шалгалт дотоод аудитын тасаг, Үйлчилгээний тасаг, Хайлааст дахь нийгмийн даатгалын Үйлчилгээний тасаг гэсэн 5 тасаг, 61 орон тоотойгоор нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хүргэж, тайлан мэдээг хуулийн хугацаанд стандартын дагуу гарган тайлагнаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хугацаанд нь биелүүлэн ажиллаж байна.




Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2023 оны “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, тогтоох, олгох ажлыг сурталчлан таниулах зорилгоор тус хэлтэс нь тэтгэвэр тэтгэмж, ажилгүйдэл, эрүүл мэндийн болон бусад ажил үйлчилгээгээр QR код бүхий заавар гарын авлага брошюр бэлтгэн, иргэд даатгуулагчид, ажил олгогч нягтлан бодогч нарт тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

Тус хэлтэс нь иргэд даатгуулагч, ажил олгогчдод үзүүлж буй үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлэн, киоск машиныг ашиглан судалгааг улирал бүр тогтмол авч хэвшин ажиллаж байна.

Энэхүү төхөөрөмж /киоск машин/-ийг ашиглан иргэн өөрт нь үйлчилгээ үзүүлсэн төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх боломжтой бөгөөд ингэснээр иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлон тус хэлтсийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг дүгнэх, байцаагч ажилтнуудын ажлын ачааллыг хэмжих, ажлын үр дүнг бодитой үнэлэх зэрэг ач холбогдолтой юм.

Иргэд даатгуулагчдыг сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарын товч мэдээлэл бүхий QR кодыг байцаагч тус бүрийн өмнө байршуулан иргэд даатгуулагчдад сурталчлан, мэдээлэл өгч ажиллаж байна.

Мөн уг төхөөрөмжийг ашиглан нийгмийн даатгалын шимтгэл төлөх дансны дугаарыг харах, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хэвлэж авах бүрэн боломжтой.



Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтэс нь байгууллагын болон албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ажилтан, албан хаагчийг урьдчилан сэргийлэх, авлигаас ангид хамт олон байх, авлига ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэрэгт холбогдохгүй байх талаар хэлтсийн нийт албан хаагчдад тухай бүр шаардлага тавьж, дотооддоо мэдээлэл, зөвлөмжийг өгч хяналт тавин ажиллаж байна.

Хэлтсийн болон Хайлааст дахь тасгийн нэг давхрын угтах үйлчилгээний үүдэнд “ДААТГУУЛАГЧ ТА АВИЛГАГҮЙ БҮСЭД НЭВТЭРЛЭЭ” ухуулга самбар байршуулсан.

Тус хэлтэс нь нийгмийн даатгалын байцаагч, албан хаагчдын ёс зүйг сахиулах, авлигын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлөөс ангид байлгах, тэднийг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн хэлтсийн нийт ажилтан албан хаагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн ажиллах талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл зөвлөгөө өгч ажилласны үр дүнд хэлтсийн 25 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ бөглөсөн бөгөөд <https://meduuleg.iaac.mn/> сайтад ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн оруулж тухайн албан хаагчийн мэдээллийг нийтэд ил нээлттэй болгон хяналт тавьж ажилласан.

Мөн шинээр болон төрийн захиргааны өөр байгууллагаас шилжин ирсэн төрийн захиргааны албан тушаалд томилогдсон 25 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж, төрийн захиргааны албан тушаалд томилогдох албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийн албан тоотыг боловсруулж, хянуулж, хүргүүлсэн.

Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг зөв мэдүүлэх, төрийн албаны ёс зүйг дээдлэн ажиллах талаар нийт албан хаагчдад тогтмол мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбоотойгоор төрийн бүх шатны байгууллагад “Шүгэл, шүүр, шувуу, шилжүүлэн авах, шил” ажиллагааг хэрэгжүүлж, нийтийн албанд хуульд заасан шаардлага хангаагүй этгээдийг томилохгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, авлига албан тушаалын гэмт хэргийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангах үүднээс авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон этгээдийг нийтийн албанаас шүүрдэх, цэвэрлэх, төрийн алба, төрийн өмчийг “шимэгчид”-ээс салгах ажлын хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шүүр” ажиллагааны хэрэгжилтийг хангах зорилгоор ирүүлсэн чиглэлийн дагуу тус хэлтэст зөрчилтэй томилогдсон албан хаагч байхгүй бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 91 тоот албан бичгээр Нийслэлийн Нийгмийн даатгалын газарт, 2023 оны 04 дүгээр сарын 05-ний өдрийн 105 тоот албан бичгээр Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн болно.

Мөн Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шүгэл” ажиллагааг дэмжиж АТГ авлигын эсрэг “НЭГДЬЕ” соён гэгээрүүлэх аяныг орон даяар эхлүүлсэнтэй холбоотойгоор авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид эрүүл нийгмийг бүтээхийн төлөө хамтдаа нэгдье урианд дор нэгдэж хэлтсийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл сурталчилгааг хүргэж ажиллаж байна.



“Налайх Хэлгэмжний Төв” ОНГААТГ





“Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ийн дагуу тус хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн “Шилэн дансны мэдээлэх албан тушаалтан томилох тухай” А/59 тоот тушаалаар шилэн дансны мэдээллийг цахим санд байршуулах, олон нийтэд хүртээх зорилгоор нэр бүхий албан хаагчдыг томилж байгууллагын үйл ажиллагааны 28 нэр төрлийн мэдээ, нийгмийн даатгалын сангийн 21 төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүр, жил бүр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтэд Нийгмийн даатгалын Ерөнхий газрын дотоод аудит мониторингийн газар болон Тус хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Мөн Цахим шилжилтийг эрчимжүүлэх, авлигын эсрэг, хүнд суртлыг арилгах “Шил ажиллагаа”-ний хүрээнд ЦХХХЯ, НЗДТГ “Шилэн төр, цахим шилжилтэд таны оролцоо” сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт тус хэлтсийн удирдлага, 10 албан хаагчид оролцлоо.

Харьцааны ёс зүй, Байгууллагын болон хувь хүний соёл, Ажил алба, Цаг ашиглалт, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх гэсэн 5 зарчмыг чанд баримтлан ажиллах, эдгээр зарчмыг зөрчвөл хуулийн дагуу хариуцлага тооцоохыг нийт албан хаагч нарт анхааруулж, байцаагч ажилтнуудын авлига, хүнд суртал, ёс зүй, зан харьцаатай холбоотой гомдол мэдээлэлд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож, нийт байцаагч ажилтнуудын ёс зүйг дээдлэн хуулийн хүрээнд шударга ажиллах, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй хүргэж, ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах, хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэх, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгож, ажилласнаар тайлант хугацаанд байцаагч, ажилтнуудын авлига, ашиг сонирхол, санхүүгийн сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой зөрчил, гомдол санал гараагүй болно.

Мөн “Ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх сургалт”-ийг зохион байгуулж, нийт байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, сургалтын файл хичээлүүдийг албан хаагчдад тараан өгч, бие даан судлуулж ажиллаж байна.

Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

Тус хэлтэс нь 2022 оны 4 улирлын байдлаар Монгол Улсын Засгийн Газрын тогтоол-4, Монгол Улсын Засгийн Газрын албан даалгавар-0, Монгол Улсын Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл-0, МУЗГ-ын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал-0, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоол-2, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар-1, тушаал-5, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан даалгавар-1, тушаал-7, Нийслэлийн Засаг даргын албан даалгавар, захирамж-0, Дүүргийн Засаг даргын 3 захирамжийг тус тус үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжилтийг хангаж, хяналтад авч ажиллаж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, өр авлага барагдуулах ажлуудыг зохион байгуулан ажилласны үр дүнд 3 улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **475122.3** сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс **547856.2** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг **115.3** хувиар давуулан биелүүлсэн.

Д/Д	Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	2023 оны 01-р сар	26,799,519.80	34,087,180.66	127%



2	2023 оны 02-р сар	28,704,804.70	36,507,075.76	127%
3	2023 оны 03-р сар	38,694,321.50	39,720,615.55	117%
4	2023 оны 04-р сар	34,857,119.50	41,148,968.31	118%
5	2023 оны 05-р сар	37,616,213.90	40,596,590.66	108%
6	2023 оны 06-р сар	42,993,990.60	55,000,528.86	128%
7	2023 оны 07-р сар	36,801,285.30	44,169,474.87	120%
8	2023 оны 08-р сар	40,858,329.00	46,601,197.00	114%
9	2023 оны 09-р сар	41,120,064.00	51,745,276.94	126%
10	2023 оны 10-р сар	40,489,132.00	49,903,206.10	128%
11	2023 оны 11-р сар	42,659,504.60	42,659,504.60	100%
12	2023 оны 12-р сар	52,377,020.00	52,377,020.00	100%
	Нийт дүн	463,971,304.90	551,666,415.61	118%

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын санд **551,666.4** сая төгрөгийн орлого төвлөрүүлж, **40210.0** сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагатай гарсан бөгөөд орлогод эзлэх авлагын хэмжээ **7.2** хувь байна.

Хамралт:

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй **16430.2** сая төгрөгийн цалингийн сан бүхий **496** аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын программд шинээр бүртгэж, мэдээллийг бүрэн оруулж, орлогын байцаагчид хуваарилан ажиллалаа. Албан журмын даатгалд **2957** даатгуулагчийг шинээр хамруулсан.

Тайлан авах ажлын хүрээнд:

2023 оны 4 дүгээр улиралд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн **4984** ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн өдрийн А/182 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хүлээн авч, хянан баталгаажуулан, байгууллага тус бүрээр хавтас нээж зохих журмын дагуу ажиллаж байна.

Вэб программаар илгээсэн зөв тайлан хүлээн авах, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулах болон холбогдох мэдээ мэдээлэл мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна.

2023 оны 4 дүгээр улиралд ажил олгогчоос цалин залруулга, нөхөн тайлан, ажил олгогчийн үйл ажиллагаатай холбоотойгоор нийт **490** албан хүсэлт, даатгуулагч иргэдээс регистр нэгтгэх, даатгуулагчийн үндсэн мэдээлэл засуулахаар нийт **226** хүлээн авч, холбогдох анхан шатны баримтыг үндэслэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.



2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 1500 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг тоон гарын үсгээр хүлээн авч ажиллаж байна. “Цахим архив” үүсгэх ажлын хүрээнд 2022 оны 1 сараас 12 сарын ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хяналт шалгалтын байцаагчаар шалгуулан, 510 хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөв.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨР АВЛАГА БУУРУУЛАХ ТАЛААР

Тус хэлтсээс 2023 оны эхний хагас жилд НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн а/16 тоот тушаалаар баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2023 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Орлого шимтгэлийн байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагууддаа авлага барагдуулах чиглэлээр өр авлага үүссэн хугацаа, авлагын насжилт, 10-аас дээш сая төгрөгийн буюу их хэмжээний өртэй, ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, албан шаардлага хүргүүлэн, авлага барагдуулах график байгуулж ажилласнаар 11886,3 сая төгрөгийн өртэй 126 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 8 ажил олгогчийн 1047,6 сая төгрөгийн өр авлага бүрэн барагдаж 74 ажил олгогчийн 7606,3 сая төгрөгийн авлага хэсэгчлэн барагдсан нийт 8653,9 сая төгрөгийн авлагыг барагдуулан ажилласан.

- 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 18357.4 сая төгрөгийн өртэй 984 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээр, 736 ажил олгогчийн 11328.7 сая төгрөгийн өр авлагыг барагдуулсан байна.
- 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар гэрээ байгуулсан боловч харилцах дансны гүйлгээг зогсоосон 2162 байгууллагын 6932.6 сая төгрөгийн авлагыг барагдууллаа.
- 2023 оны эхний авлага 35254,9 сая төгрөгийн авлагаас 20674.3 сая төгрөгийг барагдуулсан боловч, жилийн турш нийгмийн даатгалын шимтгэл их хэмжээгээр нэмэгдэж 2023 оны 4 дүгээр улиралд жилийн эцсийн авлага 40210.0 сая төгрөг болж өслөө.

Нийт хуримтлагдсан авлагын 21,1 тэрбум төгрөг буюу 48% хувийг худалдаа үйлчилгээ, барилга, зам тээвэр, уул уурхайн салбарууд эзэлж байна. Зам, барилгын салбар нь улсаас тендер авч урьдчилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг тухайн ажил олгогч хариуцаж гүйцэтгэдэг ба барилга болон замын гүйцэтгэл бүрэн дууссаны дараа улсын төсвөөс санхүүжилтээ авдаг. Төслийн хугацаанд бараа материал, тээврийн үнэ огцом нэмэгдэж дээрх салбарууд алдагдал хүлээж, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаандаа төлж чадахгүй өр хуримтлагдаж байна. Хэлтсийн үйл ажиллагаанаас үл хамаарч нийгэм, эдийн засгийн хямрал нөлөөлж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд шимтгэлээ төлөхгүй удаашралтай байна.

Албан хэрэг хөтлөлтийн ажлын хүрээнд

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ирсэн бичиг, өргөдөл, гомдлыг цаасан суурьтайгаар болон Абле, Edoc программаар цахимаар хүлээн авч холбогдох байцаагчид шилжүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлүүлж ажиллаж байна.

Хэлтсийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд анхаарч албан бичиг шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон



шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд хэлтсийн даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Иргэд, болон аж ахуй нэгж байгууллагаас нийт 684 албан хүсэлт, өргөдөл хүлээн авснаас Абле программаар 183, Edos программаар 501 албан хүсэлт, өргөдлийг холбогдох хавсралт нотлох баримтуудыг шалган бүртгэл хөтлөн хэлтсийн даргаар цохуулж холбогдох ажилтанд шилжүүлж, хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлэн ажиллаж байна. 684 албан хүсэлт, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж шийдвэрлэлтийн дундаж 100 хувийн биелэлттэй байна.

Цалин залруулга: 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар ажил олгогчоос ирүүлсэн 318 албан хүсэлт, анхан шатны нотлох баримтыг үндэслэн даатгуулагчийн цалин, төрлийн кодыг залруулсан байна. Мөн даатгуулагчийн өргөдөл, нотлох баримтыг үндэслэн 226 даатгуулагчийн үндсэн мэдээлэл, овог нэр, регистрийг өөрчилж бүртгэл засав.

Шүүхэд нэхэмжилсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлага

Тус хэлтэс нь нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй шүүхэд нэхэмжилсэн аж ахуйн нэгжийн өрийг барагдуулахаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар харьяа дүүргийн шүүхэд нийгмийн даатгалын хуримтлагдсан авлага барагдуулах талаар холбогдох баримт материалыг хавсарган **71** ажил олгогчийг шүүхэд нэхэмжилсэн.
- Үүнээс 18 ажил олгогчийн эзэн холбогдогч, хаяг байршил тодорхойгүй шалтгаанаар анхан шатны шүүхээс материал буцсан тул хариуцагчийг *эрэн сурвалжлуулахаар*, 7 ажил олгогчийг шүүгчийн шийдвэр албадан гүйцэтгүүлэхээр анхан шатны шүүхэд хүсэлт гаргасан.
- Өр барагдуулах талаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу Чингэлтэй дүүргийн Прокурорыг зохигчоор оролцуулж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаар хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлага

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 28 аж ахуйн нэгж байгууллагын **2750.5 сая** төгрөгийн өр барагдуулах явцыг эрчимжүүлэх зорилгоор өр барагдуулалтын судалгаа гаргаж, шийдвэр гүйцэтгэгч болон байцаагч нарт бодит мэдээллээр хангаж ажиллаж байна. Үүнээс 211 сая төгрөгийн өртэй **8** аж ахуйн нэгж байгууллагын шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл шалтгаанаар түдгэлзүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зогссон ажил олгогчийн жагсаалтаар харуулбал:

№	Ажил олгогчийн нэр	АО регистрийн дугаар	Шүүхийн мөнгөн дүн	Үлдэгдэл	Түдгэлзүүлсэн тайлбар
1	Хайб концепт	4403312	10,728,309.00	10,676,509.00	Төлбөр гаргуулж болох хөрөнгө, орлого байхгүй бөгөөд хуульд заасан аргаар түүний хөрөнгө, орлогыг албадан гаргуулах боломжгүй бол төлбөр төлөгчийг хөрөнгөтэй болох хүртэл.
2	Анирдэлхий	5472695	13,711,076.00	13,711,076.00	Төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл. (27.2.6)
3	Хос-Эверест	2885816	19,241,519.00	14,241,519.00	Нэгтгэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх (28-р зүйл)
4	Өнөмөнх монгол	2620057	5,813,973.00	5,813,973.00	Төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл. (27.2.6)



5	Эвсэгмонгол	5032636	20,717,272.00	16,407,728.00	Төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл. (27.2.6)
6	Хос-Эверест	2885816	19,241,519.00	14,241,519.00	Нэгтгэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх (28-р зүйл)
7	Батжилхоулд	5269075	10,111,876.00	10,111,876.00	төлбөр төлөгч-иргэн, эсхүл төлбөр төлөгч-хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгч, тэдгээрийн эд хөрөнгийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл. (27.2.6)
8	Паркнайн ХХК	5241626	125,837,692.00	125,837,692.00	Нэгтгэн явуулж байгаа иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх (28-р зүйл)
НИЙТ			225,403,236.00	211,041,892.00	

2573.5 сая төгрөгийн өртэй 15 аж ахуйн нэгж байгууллагад өр барагдуулах гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа бөгөөд 4 дүгээр улирлын байдлаар 386,4 сая төгрөг барагдуулсан байна. Үүнээс 2 ажил олгогчийн авлага бүрэн барагдсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж буй аж ахуйн нэгж байгууллагыг жагсаалтаар харуулбал:

№	Ажил олгогчийн нэр	АО регистрийн дугаар	Шүүхийн мөнгөн дүн	Үлдэгдэл	Тайлбар
1	Тэдмэнтсекьюрити	5745837	20,720,976	13,100,000	Бүрэн барагдуулсан
2	Мерекс ХХК	5631084	185,628,970	180,628,970	Ажиллагаанд байгаа
3	Баянхөндий трейд ХХК	2692929	90,542,115	87,142,115	Ажиллагаанд байгаа
4	Гантолбо ХХК	5318688	15,365,300	13,585,300	Ажиллагаанд байгаа
5	Пикюрис ХХК	5198038	14,806,399	14,369,158	Ажиллагаанд байгаа
6	Пауэрложистик ХХК	5094569	34,650,589	34,650,589	Ажиллагаанд байгаа
7	Хаммер монголиа ХХК	5349079	20,960,556	20,960,556	Ажиллагаанд байгаа
8	Бласт мануфактуринг ХХК	5471834	95,674,398	80,674,398	Ажиллагаанд байгаа
9	Пикюрис ХХК	5198038	14,806,399	14,369,158	Ажиллагаанд байгаа
10	Хаммер монголиа ХХК	5349079	20,960,556	20,960,556	Ажиллагаанд байгаа
11	Эрдэнэтолгой ресорсэс ХХК	5538394	59,097,175	58,097,175	Ажиллагаанд байгаа
12	Монгема ХХК	2641194	71,828,119	71,828,119	Ажиллагаанд байгаа
13	Цагаанбар секьюрити ХХК	2555174	51,559,582	51,559,582	Ажиллагаанд байгаа
14	Могоулскай ХХК	5087384	25,011,400	25,011,400	Ажиллагаанд байгаа
15	Аржроуд ХХК	5286859	1,496,146,699	1,253,146,699	Ажиллагаанд байгаа
16	Талсттехнологи ХХК	5647681	72,805,700	-	Бүрэн барагдуулсан
17	Номтын ам ХХК	5196256	39 837 685.95	39837685.95	Ажиллагаанд байгаа
18	Ай синема ХХК	6038727	64 221 578.79	64221578.79	Ажиллагаанд байгаа
19	Лакс ХХК	2676362	73 117 119.53	73117119.53	Ажиллагаанд байгаа
20	Ногоон сор ХХК	539407	16 962 600	16 962 600	Ажиллагаанд байгаа
НИЙТ			2,519,354,505	2155773348.27	



Шүүхээр нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй болох нь тогтоогдсон шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийг албадан гүйцэтгүүлэхээр **350.8** сая төгрөгийн өр авлагатай **11** аж ахуйн нэгж байгууллагыг Банк хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанд шилжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ШГА/01НД52 тоот “Хамтран ажиллах, мэдээлэл солилцох тухай гэрээ” байгуулсны дагуу шүүхийн шийдвэрт шилжүүлсэн өр авлагыг барагдуулах, шүүхийн шийдвэрийн өр авлага 11%-ийн барагдуулалттай байгаа нь хангалтгүй тул ажлыг эрчимжүүлэх зорилгоор тус хэлтсээс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 559 тоот “Өр авлага эрчимжүүлэх тухай” албан тоотыг хүргүүлсэн болно.

САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ТАЛААР

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 15550 сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс шинээр 2100 даатгуулагч, 1120 эхчүүдтэй гэрээ байгуулан ажилласнаар нийгмийн даатгалын санд 10454 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 8500.2 сая төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 81.3 хувиар биелүүлсэн байна.

2023 оны 4 дүгээр улиралд сайн дураар даатгалын гэрээ байгуулсан боловч хуулийн хугацаанд шимтгэлээ төлөөгүй хугацаа хэтэрч төлсөн 1500 даатгуулагчид нийт 35.2 сая төгрөгийн алданги ногдуулж алдангийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.

2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хэлтсийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2023 оны 4-р улирлын тайлангаар гарсан кредит үлдэгдлийг бууруулах зорилгоор ажил олгогч байгууллага, сайн дурын даатгуулагчтай давхардсан 220 даатгуулагчийн шимтгэлийг өргөдлийн дагуу буцаан олгож шийдвэрлэсэн.

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар сайн дурын даатгалын шимтгэл 948,3 сая төгрөгийн кт-ийг 868 сая төгрөгөөр бууруулж, ногдуулалт хийж гэрээг шинэчилсэн.

Сайн дурын даатгалаас сайн дураар даатгуулагч эх рүү шилжүүлэх 43,8 сая төгрөгийн гүйлгээний жагсаалтыг сайн дураар даатгуулагч эхээс сайн дурын даатгал руу шилжүүлэх 13,9 мянган төгрөгийн гүйлгээний жагсаалтаар сангийн нягтлан бодогчтой тулган гүйлгээг хийсэн.

Даатгуулагч дээр 2 бүртгэл үүссэнийг залруулж 252 иргэний 67,4 сая төгрөгийн гүйлгээний жагсаалт хийн орлогын сангийн нягтланд өгч залруулсан.

Сайн дурын даатгал аймаг, дүүрэгтэй давхардсан 23 даатгуулагч Хайбрид ээж, сайн дурын даатгуулагчтай давхардсан 9 ээжийг залруулсан. Сайн дурын даатгуулагч давхар ногдуулалт хийсэн 28 даатгуулагч, Ажил олгогч, Хайбрид ээжтэй давхардсан 39 даатгуулагчийг засаж залруулсан. Абле программ дээр ирсэн 61 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Тус хэлтсээс 2023 оны 05 сарын 01-ны өдрийн 518 тоот бичгээр Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй 0-3 хүртэлх насны 921 даатгуулагч эхийн судалгаа авч сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Үүнээс 472 даатгуулагч эх сайн дурын даатгалын шимтгэл төлдөггүй тул утсаар холбогдож нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээллийг өгч 75 даатгуулагч эхийг сайн дурын даатгалд хамруулсан байна. Цаашид хамралтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААР

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар эрүүл мэндийн даатгалын санд 1109.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 1192.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэн 107 хувийн биелэлттэй байна.

Шинээр их дээд сургуулийн оюутан суралцагч 683, гадаадын иргэн харьяалалгүй 10 даатгуулагч, ажил хөдөлмөр эрхлээгүй 14068 нийт 14765 даатгуулагч иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, сунгалтыг хийн баталгаажуулав. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагчдын мэдээллийг өдөр бүр шалгаж, ногдуулалтыг хийж ажилласан. Улирал бүрийн тайлан гаргах хугацаанд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн үлдэгдэл бууруулж ажилласан даатгуулагч иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл бүртгэл, ногдуулалтыг хугацаанд нь үнэн зөв хийж, даатгуулагчдад түргэн



шуурхай, чирэгдэлгүй үйлчилж байна. Оюутан суралцагчид тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, гадаадын иргэн харьяалалгүй иргэдийг эрүүл мэндийн даатгал хамруулж ажиллаж

2.5. Албан хэрэг хөтлөлтийн ажлын хүрээнд

Ирсэн бичиг болон явуулсан бичиг, өргөдөл, гомдлыг цаасан суурьтайгаар болон Абле, Edoc программаар цахимаар хүлээн авч хэлтсийн удирдлагад танилцуулан холбогдох тасгийн дарга, мэргэжилтнүүдэд хуулийн хугацаанд шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллаж байна.

Хэлтсийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд анхаарч албан бичиг шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд хэлтсийн даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Абле программаар НДЕГ болон дотоод байгууллагаас ирсэн нийт өргөдөл, гомдол 208 ирж хуулийн хугацаанд шийдвэрлэж, албан бичгээс хариутай 208 бичгийг шийдвэрлэсэн.

Edoc программаар нийт 501 албан бичгийг цаг тухайд нь шийдвэрлэсэн ба 17 бичиг хяналтын шатанд байна. Тус хэлтэс нь тайлант хугацаанд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой нийт 179 бичгийг Edoc программ ашиглан явуулсан.

Ажлын байран дээрх эмх цэгц үйлчилгээний стандартыг хэвшүүлэх зорилгоор НДЕГ-аас хэвлэн гаргасан “Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний гарын авлага” номыг хэлтсийн нийт албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн MNS 5140-1:2011, MNS 5140-3:2011 стандарт, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” журмын дагуу үйлдэгдэж Нийслэлийн Архивын газрын дарга цаасан суурьтай баримт бичгийг тайлант хугацаанд архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн. Өргөдөл гомдлын шийдвэрлэлийн мэдээг улирал бүр нийт албан хаагчдад танилцуулж, зөрчил гаргасан албан хаагчдад сануулах арга хэмжээг тухай бүр нь авч ажиллаж байна.

2.2 Тэтгэвэр тэтгэмж олголтын талаар

Тус хэлтэс нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 28-ны тогтоолын дагуу хуулийн хугацаанд нь нийт 23680 иргэний тэтгэврийг дахин итгэлцүүрээр шинэчлэн бодож баталгаажуулалтыг хийж ажилласан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр авагч 21589, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2355, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 994, **нийт 24938** иргэний тэтгэврийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй түргэн шуурхай олгон ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр хэрэгжиж буй Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, нэмэлт өөрчлөлтүүдийн талаар иргэд, даатгуулагч нарт тухай бүр зөвлөгөө мэдээлэл 2023 оны 11 дүгээр сарын 04, 11-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн ахлаг нартай хамтран иргэд даатгуулагч нарт хуулийн зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Мөн нэг цэгийн үйлчилгээнд иргэдэд зөвлөгөө мэдээллийг түргэн шуурхай хүргэж, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй тэтгэврийн насыг үе шаттайгаар нэмэгдүүлэх хуулийн хүрээнд 2022 онд 60 нас хүрч буй эрэгтэй, 55 нас хүрч буй эмэгтэй даатгуулагч нийт 21 жил 6 сар түүнээс дээш хугацаанд шимтгэл төлсөн тохиолдолд насандаа, ажилласан жил хүрэхгүй тохиолдолд 1 жил 6 сараар нас ухарч тэтгэвэр тогтоолгох болзол үйлчилж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэд, даатгуулагчдад зөвлөгөө өгөх, тэдэнд баримт бичгээ эрх зүйн үндэслэлтэй зөв бүрдүүлэхэд нь туслах, зөрчилтэй баримтын зөрчлийг нь арилгуулах, дутуу баримтыг гүйцээж бүрдүүлэх, холбогдох лавлагааг



архиваас хэрхэн гаргуулах зэрэг асуудлаар Чингэлтэй дүүргийн 1-24 хорооны нийт 1620 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Тус хэлтэс нь 2023 оны жилийн эцсийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр насны- 1362, тахир дутуугийн- 483, тэжээгчээ алдсаны- 112, цэргийн тэтгэвэр авагч 15, малчин тэтгэвэр 2, нийт 1974 даатгуулагчийн баримт материалыг хүлээн авч шинээр тэтгэвэр тогтоон, бүртгэл хөтлөн ажилласан.

Чингэлтэй дүүргийн 1-24 хороонд буюу тус хэлтэст нийт өндөр насны тэтгэвэр авагч, тахир дутуугийн тэтгэвэр авагч, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч нийт 194 иргэний тэтгэврийн хувийн хэрэг шилжин ирж, 287 тэтгэвэр иргэний харъяаллын дагуу шилжин явсан байна. Мөн 2023 оны жилийн байдлаар нийт 512 тэтгэвэр зогсоогдсон, цуцлагдсан, нас барсаны хөдөлгөөнийг хийж баталгаажуулан, хяналт хийж жагсаалтаар хадгаламжийн нэгж үүсгэсэн. Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн дагуу тэтгэврийн нэмэгдэл, ажилласан жил нэмүүлэх, ажилласан жилийг шалгуулах, цалингийн дундаж сонгох, жишиг цалин оруулах зэрэг нийт цахим болон цаасан хэлбэрээр 892 тэтгэвэр авагч иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Тэтгэвэр авагчдын тэтгэвэр олголтын файлыг сар, 7 хоног бүрийн баасан гаригуудад хянаж бэлтгэн харилцагч Төрийн, Хаан, Худалдаа хөгжил, Голомт банкны салбаруудад файлыг дамжуулж тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Иргэд даатгуулагчдад тэтгэвэр олгох нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх талаар арилжааны Төрийн, ХААН, Худалдаа хөгжил, Голомт банкуудтай хамтран ажиллаж, байгууллагуудын хооронд гарсан зөрчил дутагдлыг тухай бүр нь шийдвэрлэж ажиллаж байна.

Тус хэлтэс нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн 1/1594 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” зөвлөмжийг баримтлан шимтгэлийн өр авлагатай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг аж ахуйн нэгж байгууллагаар нөхөн төлүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах гэрээг байгуулсан даатгуулагч нарын тэтгэмжийг хуулийн дагуу бодож олгож байна. Үүнд:

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 5799 даатгуулагчдад 1 289,2 сая төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 1984 даатгуулагчдад 5 822,6 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 122 иргэний 243.0 сая төгрөг, 722 даатгуулагчийн 2 671,5 сая төгрөгийг тус хуулийн хугацаанд олгож ажилласан байна.

Хэлтсийн даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны “Тэтгэврийн хувийн хэргийг тоолох, олголттой тулган шалгах” удирдамжийн дагуу ажлын хэсэг томилогдож, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг дэлгэрэнгүй бүртгэлийн нэгтгэл /ЗН-НД-6/, тэтгэвэр авагчийн хувийн хэргийн тооллогын нэгтгэл /ЗН-НД-7/ маягтаар актыг үйлдэж, 2023 оны 02 дугаар сарын 06-наас 24 хооронд тооллогыг хэлтсийн хэмжээнд 1-24 хорооны 24107 тэтгэврийн хувийн хэргийг тэтгэвэр авагчийн тоо, хувийн хэрэг олгосон тэтгэврийн дүнтэй тулган шалгах ажлыг зохион байгуулж ажилласан.

Мөн Нийслэлийн нийгмийн даатгалын газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны 02 тоот “Урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт хийх нэгдсэн удирдамж”-ын дагуу 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс хэлтсийн 2019-2022 оны тэтгэврийн хувийн хэрэг, хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоолгосон тэтгэвэрийн хувийн хэргийг татан авч, 7500 гаруй тэтгэврийг шалгаж, 10902 тэтгэвэр олголтын үндэслэлийг шалгуулж, ажилласан. Шалгалтаар илэрсэн тэтгэвэр дутуу олгосон 8 хүнд холбогдох 2,916,922 (Хоёр сая есөн зуун арван зургаан мянга есөн зуун хорин хоёр) төгрөгийн тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас нэг удаа нөхөн олгох;

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 31/14 тоот улсын байцаагчийн актаар тогтоогдсон 8 тэтгэвэр авагчийн 2916 922 төгрөгийн дутуу олгогдсон зөрчилд сангийн нягтлан бодогч, хариуцсан тэтгэврийн байцаагч, хяналт шалгалтын байцаагч нар хамтран тэтгэврийн материалыг шалгаж, гарсан зөрчлийн биелэлтийг хангуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчийн материалыг татаж, тэтгэвэр авагчидтай уулзалтыг хийж зөрчлийг танилцуулсан. Үүнд: 7 иргэнтэй холбоотой 2136117 төгрөгийг 2023 оны 5 сард нөхөж олгож, 2023 оны 06 дугаар сард 1 иргэний 770 805 төгрөг



буюу нийт 2 916 922 төгрөгийг 100 хувь барагдуулж ажилласан. Мөн 18 иргэнээс 16 иргэнд тэтгэврийн илүү олгосон зөрчлийг танилцуулж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 29.2 дахь заалтыг үндэслэн, 15 иргэний тэтгэврийг санд төлүүлж, үүнээс 6 иргэн нь 1460 271 төгрөгийн илүү тэтгэврийг буцаан тэтгэврийн санд төлж 100 хувийн барагдуулалт хийсэн. 7 иргэн нь төлөлтийн график байгуулж, нийт 15 иргэний 3 447 115 төгрөгийг тэтгэврийн санд нөхөн төлүүлж 13,6 хувийн биелэлттэй ажиллаж байна.

2.3 Хяналт шалгалтын ажлын хүрээнд

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2023 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, тэтгэврийн нэмэгдлийг индексжүүлж өөрчлөн тогтооход анхаарч ажиллах, дотоодын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зэрэг ажил төлөвлөн ажиллалаа. Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд бодлогын баримт бичгийг стандартын дагуу гарган тайлагнах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 сарын 01-ний өдрийн 06/410 тоот удирдамж, Хэлтсийн даргын 01 тоот тус тус удирдамжийн дагуу ажил олгогчдод Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, хуримтлагдсан өр авлагыг бууруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр ажил олгогчийн жагсаалт гарган батлуулж хуваарийн дагуу байцаагчид хяналт шалгалт хийж байна. Тайлант хугацаанд нийт 211 ажил олгогчийг шалгаж зөрчил илрүүлж 205.3 сая төгрөгийн акт 132,2 сая төгрөгийн алданги тооцож бүгд 337,5 сая төгрөгийн акт алдангийг 100 хувь барагдуулан ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл код, цалин хөлсийг илүү буюу дутуу тооцсон зөрчлийг арилгаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн А/50 тоот тушаал, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/182 тоот журам /Маягт-2, маягт -3 тоот /-н дагуу засварын тайланг батлагдсан маягтын дагуу ажил олгогчоор баталгуулж цалин, төрөл код засварлан шийдвэрлэсэн.

Цахим хяналтын талаар:

Цахим хяналтын системд тулгуурлан дотоодын хяналт шалгалтын мэдээллийг тогтмол хийж байна. 2023 оны байдлаар өргөдөл, ажил олгогчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу цалингийн мэдээлэл устгасан, өөрчилсөн, код буруу шивэгдсэн, нөхөн тайлан өгсөн, Улсын байцаагчийн актаар тайлан шивсэн зэрэг нийт давхардсан тоогоор 5930 даатгуулагчийн баримтыг үндэслэн цахим хяналтыг мэдээллийн сантай тулган нотлох баримтыг хавсарган залруулан ажиллаж байна.

Мэдээлэл тооцоолох төвөөс ирүүлсэн Цахим хяналтын систем” (<http://10.9.0.5/monitoring>)-д зөрчлийн шийдвэрлэлтийн тэмдэглэл хөтөлж, хянасан байдал 2022 онд 98%-тай байна.

Үүнд:

1. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл даатгуулагчаар-1094-100%
2. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл АО-1696-1696 буюу 100%
3. Шимтгэл-Регистр нэгтгэсэн даатгуулагч-311-100%
4. Шимтгэл-НДШ төлсөн тэтгэвэр авагч код буруу-189-100%
5. Шимтгэл-даатгуулагчийн төрөл буруу-325-100%
6. Жир амаржсаны эрх хянах 15-100%
7. Жир амаржсаны цалин хянах 627-100%
8. Ажилгүйдлийн тэтгэмжийн эрхийн нөхцөл хянах 33-100%
9. Ажилгүйдлийн тэтгэмжийн цалин хянах 57-100%
10. Ажилгүйдлийн тэт хугацаа хэтэрсэн 11-100%
11. Ажилгүйдлийн тэтгэмжийн цалин давхардсан 724 -2-99,6%

Бүгд 5930 даатгуулагч ажил олгогчийн мэдээлэл засварласан.

2023 онд цахим хяналтын програмаас гаргасан мэдээллийг шалгаж 97%-тай байна. Үүнд:

1. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл даатгуулагчаар-751-100%



2. Шимтгэл-Цалин өөрчилсөн мэдээлэл АО-831-63 буюу 92,4%
3. Шимтгэл-Регистр нэгтгэсэн даатгуулагч-30-100%
4. Шимтгэл-НДШ төлсөн тэтгэвэр авагч код буруу-1558-488-68,7%
5. Шимтгэл-даатгуулагчийн төрөл буруу-144-100%
6. Жир амаржсаны эрх хянах 13-100%
7. Жир амаржсаны цалин хянах 8-100%
8. Ажилгүйдлийн тэтгэмжийн цалин хянах 43-100%

Бүгд 5930 даатгуулагчийн цахим хяналтын програмаар гарч ирсэн зөрчлийг мэдээллийн нэгдсэн сантай тулган шалгаж зөрчил илрээгүй иргэдийн тэмдэглэлийг цахимд зөрчлийн шийдвэрлэлтийн тэмдэглэл хөтөлж орууллаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд даатгуулагчийн төрөл код, цалин хөлсийг илүү буюу дутуу тооцсон зөрчлийг арилгаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн А/50 тоот тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/186 тоот тушаал /Маягт-2, маягт -3 тоот /-н дагуу засварын тайланг батлагдсан маягтын дагуу ажил олгогчоор баталгуулж цалин, төрөл код засварлан шийдвэрлэсэн.

Дотоод хяналт шалгалтын талаар:

Тус хэлтэс нь 2023 оны байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 1347 тэтгэвэр авагчийн баримт материалыг хянан шалгаж, тэтгэвэр тогтоох үндэслэл, бүрдүүлсэн баримт бичгийг нягтлан шалгаж ажилласан.

Мөн 12381 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 4194 даатгуулагчийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн цалин, эрх үүсэж байгаа эсэхийг хянаж, мөн 722 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмж, 452 даатгуулагчийн оршуулгын тэтгэмж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох 119 даатгуулагчийн ХЧТА-ны тэтгэмж, нийт **7785** даатгуулагчийн мэдээллийг хянаж тэтгэмж авах хугацааг тэтгэмжийн програмтай тулган шалгаж хяналт тавин ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 03 сарын 01-ны өдрийн 06/410 тоот удирдамж, Хэлтсийн даргын 01 тоот тус тус удирдамжийн дагуу ажил олгогчдод Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, хуримтлагдсан өр авлагыг бууруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр ажил олгогчийн жагсаалт гарган батлуулж хуваарийн дагуу байцаагчид хяналт шалгалт хийж байна. Тайлант хугацаанд нийт 211 ажил олгогчийг шалгаж зөрчил илрүүлж 205,3 мян төгрөгийн акт 132,2 сая төгрөгийн алданги тооцож бүгд 337,5 сая төгрөгийн акт алдангийг 100 хувь барагдуулан ажиллалаа.

Оны эхэнд 11 даатгуулагчийн 76,6 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй гарсан.

Тайлант хугацаанд 72 даатгуулагчийн 208,2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн зөрчил илэрч 99,2 сая төгрөг барагдаж үлдэгдэл 257,4 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулахаар ажиллаж байна.

Улсын байцаагчийн актын үлдэгдэлтэй нэр бүхий иргэдийг шүүхэд шилжүүлэн тэтгэвэр, тэтгэмжийн санг хохиролгүй болгохоор ажиллаж байна.

Шалгалтаар Номадс катеринг энд ин.сервис ХХК-71482000 төгрөг, Зонне дент ХХК-4821480 төгрөг, Мүгэн фүүдс ХХК-15000000 төгрөг, Монтой Эрдэнэ ХХК-338102502 төгрөг, М-ойл ХХК-40000000 төгрөг, Ривер скай констракшн ХХК-19240000 төгрөг, Саусгоби брэндс ХХК-30286599 төгрөг нийт 518932581 төгрөгийг санд бүрэн төвлөрүүлсэн байна.

2023 оны эхэнд дотоодын болон хөндлөнгийн хяналт шалгалтаар тэтгэвэр тэтгэмжийн илэрсэн зөрчилд 11 даатгуулагчийн 76 663 355 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй гарсан. Тайлант хугацаанд Нийслэлийн нийгмийн даатгалын газрын хяналт шалгалт, дотоодын шалгалтаар 280022842 төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоож 99245,9 сая төгрөгийг бүрэн барагдуулж, өр төлбөрийг барагдуулахаар тэтгэврээс суутгах, график байгуулах, шүүхэд шилжүүлэх гэх мэт хуулийн дагуу шат дараатай арга хэмжээ авч тэтгэвэр, тэтгэмжийн санг хохиролгүй болгохоор ажиллаж байна.



Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 4984 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хэлтсийн даргын баталсан 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 02 тоот удирдамжийн дагуу дотоодын хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Орлого, шимтгэлийн тасгийн байцаагч нарын хариуцдаг ажил олгогчийн ирүүлсэн тайланд шимтгэл ногдуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагчийн төрөл, тайлан авалтын хугацаа, нөхөн тайлангийн үндэслэл болон залруулгын тайлан зэргийг мэдээллийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь арилгуулж цахим хяналт шалгалтын програмд үүсгэгдсэн мэдээллийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Хөндлөнгийн хяналт шалгалтын талаар:

ННДГ-аас удирдамжийн дагуу шалгалт хөнгөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын хувийн хэргийн материалд үндэслэн шалгалт хийгдэж нийт 31 даатгуулагчийн 1075526732 төгрөгний зөрчил бүхий тэтгэвэр авагчтай холбоотой баримтыг дотоодын хяналт шалгалтаар зөрчлийг арилгуулахаар албан даалгавар ирүүлсэн. Үүний дагуу нэр бүхий тэтгэвэр авагчдын баримтыг шалгаж 10 иргэнд 179 625 341 төгрөгийн төлбөр зөрчилд акт тогтоож хяналт шалгалт хийж ажиллалаа.

НДЕГ, ННДГ-ын актын барагдуулалтын талаар:

НДЕГ, ННДГ-ын 2014-2020 онуудын тэтгэврийн даатгалын санд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил болох 67,4 сая төгрөгөөс 25,6 сая төг барагдуулж, 41,8 сая төгрөгийг барагдуулаагүй байна.

Өндөр насны тэтгэвэр авагч иргэний тэтгэврээс 50%-иар тооцож суутгал хийгдэж байгаа учраас актын барагдуулалт удаашралтай хугацаа их шаардагдаж байна.

Нас барсан иргэний акт болон буруу тооцооллоос шалтгаалан тавигдсан акт, төлбөр зөрчлийг НДЕГ-т хандаж актыг хүчингүй болгох тухай хүсэлт гаргах материал бүрдүүлэн ажиллаж байна. Зарим төлбөр зөрчлийг төлүүлэхээр харьяалах шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна.

ННДГазраас улсын байцаагчийн актаар тогтоосон өндөр насны тэтгэвэр авагч З.Гаваагын 2385,5 мян төгрөгийн ШШГГ-т шилжсэн авлагийг барагдуулхаар ажиллаж байна.

НДЕГазраас 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 37 тоот улсын байцаагчийн актаар тогтоогдсон ажилгүйдлийн тэтгэмж Дөмөгмаа /Н367062568/-н 2171,7 сая төгрөгийг барагдуулахаар ЧД-ийн шүүхэд нэхэмжлэл гарган ажиллаж байна.

НДЕГазраас 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 38 тоот улсын байцаагчийн актаар тогтоогдсон жирэмсэн амаржсаны тэтгэмж авсан Дэлгэрмаа /ОЮ73030602/-н 558,3 сая төгрөгийн актыг хүчингүй болгох хүсэлт хүргүүлэхээр материал бүрдүүлэн ажиллаж байна.

ННДГазраас улсын байцаагчийн актаар тавигдсан Төгсбаяр /ХВ79082418/ ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон 2,4 мян төгрөгийг төлүүлэхээр ЧД-ийн шүүхэд нэхэмжлэл гаргасан болно.

2014 оны 11 сарын 20-ны № 147 тоот улсын байцаагчийн актаар тогтоогдсон илүү олгосон тэтгэвэр авагч /нас барсан/ С.Ганбаатар 159,3 мян.төгрөг, С.Отгонбаатар 848,2 мян төгрөг, Д.Эрдэнэбилэг 176,1 мян төгрөгийн актыг тус тус хүчингүй болгуулахаар НДЕГ-т хүсэлт хүргүүлэхээр материал бүрдүүлэн ажилласан.

Дээд газрын болон дотоодын актын барагдуулалтын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, НДЕГ-ын дотоод аудитын газарт гарган хүргүүлсэн.

Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд доорхи арга хэмжээ авч ажилласан. Үүнд:



Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хоцроосон тухай хүсэлтээ өгсөн 5 байгууллага хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 10.17.4 дэх заалтыг үндэслэн 2000000 /хоёр сая/ төгрөгийн торгууль оногдуулж, хялбаршуулан шийдвэрлэсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тайлагнаагүй, даатгуулагч орхигдуулсан тухай хүсэлтээ өгсөн 5 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 10.17.4 дэх заалтыг үндэслэн 2000000 /хоёр сая/ төгрөгийн торгууль оногдуулан Чингэлтэй дүүргийн прокурорын газарт хянуулан хялбаршуулан шийдвэрлэсэн.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 100 хувиар барагдуулсан байна.

/мян төгрөг/

Байгууллагын нэр	Шимтгэлийн дүн	Алдангийн дүн	Торгуулийн дүн
RUNEEters ХХК	388300	-	250,0
СБМ ХХК	167400	-	250,0
Эм ти юу ХХК	581400	147286	250,0
Хар алтан орд ХХК	8500000	2550000	500,0
Граф нетборк ХХК	8964000	2689200	1000,0
Дүн	18601100	5386486	4000,0

Чингэлтэй дүүргийн прокурорт Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж, шийтгэл оногдуулсан материал болон шийтгэл оногдуулсан зөрчлийн хэрэгт оролцогчдоос гомдол гаргасан эсэх талаар судалгааг цаг тухай бүрт нь гарган хүргүүлэн ажиллалаа.

Дээд шатны байгууллага болон Хэлтсийн даргын гаргасан тушаал шийдвэрийн талаар:

Хэлтсийн даргын баталсан 2023 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 02 тоот удирдамжийн дагуу Орлого, шимтгэлийн тасгийн байцаагч нарын хариуцан ажилладаг ААНБ-ын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон ногдуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагчийн төрөл, тайлан авалтын хугацаа, нөхөн тайлангийн үндэслэл болон залруулгын тайлан зэргийг мэдээллийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрэн арилгуулан шалгалаа. Орлого, шимтгэлийн байцаагчийн хүлээн авсан ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлийг НДЕГ-н даргын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/186 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн заавар”-ыг баримтлан ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон шимтгэлийн тооцооны программын үлдэгдлүүдийг тулган, шимтгэлийн өр авлагатай ААНБ-тай хийсэн тооцоо нийлсэн актын баталгаажуулалт мөн тоон гарын үсгээр баталгаажуулсан нийт 4672 тайланг шалгалаа. Цаашид анхаарах зүйл:

- Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчид шимтгэл төлөлтийн тайлангаа илгээхийн өмнө “Тайлан шалгах” цэсээр орж, даатгуулагчийн кодын төрөл тус бүрийг сонгон шалгасны дараа байцаагчид илгээхийг сануулж, зөвлөгөө өгч ажиллах
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/182 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах, баталгаажуулах журам”-ын дагуу тайланг хүлээн авч баталгаажуулж ажиллах.



- Шимтгэлийн программд ажил олгогчийн хаяг байршил, захирал, нягтлан бодогчийн нэр, утасны дугаар, аж ахуйн нэгжийн харилцах дансны мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүр шинэчилж засварлах
- Шимтгэл төлөлтийн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх сарын тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тохирч байгаа эсэх, төлсөн шимтгэл, ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчийн гарын үсгийн тайлал, тамга тэмдгийг шалгаж, тооцоо нийлсэн акт үйлдэх
- Ажил олгогч үйл ажиллагаагаа сэргээн явуулах болон үйл ажиллагаа зогсооход албан бичиг авч, ажил олгогчийн тайлангийн хавтсанд хийж байх.

Тэтгэвэр болон тэтгэмжийн баримтыг бүрэн бүрдүүлсний дараа хүлээн авч мэдээллийн нэгдсэн санд оруулж байх талаар байцаагч нар цаашид анхаарч ажиллах шаардлагатай

Өргөдөл гомдлын шийдвэрлэлийн талаар:

2023 оны жилийн эцсийн байдлаар ирсэн бичиг болон явуулсан бичиг, өргөдөл, гомдлыг цаасан суурьтайгаар болон Абле, Edoc программаар цахимаар хүлээн авч хэлтсийн удирдлагад танилцуулан холбогдох тасгийн дарга, мэргэжилтнүүдэд хуулийн хугацаанд шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллаж байна.

Хэлтсийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд анхаарч албан бичиг шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд хэлтсийн даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Абле программаар НДЕГ болон дотоод байгууллагаас ирсэн нийт албан бичгээс хариутай 120 бичгийг шийдвэрлэсэн ба 5 албан бичиг хяналтын шатандаа 115 албан бичгийг бүрэн шийдвэрлэж ажилласан байна. Мөн Абле программаар 80 өргөдөл ирүүлснийг 75 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна

2.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын ажлын талаар

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12р сарын 09-ний өдрийн “Даатгуулагч / иргэн /-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацаа”-г тогтоох А/758 А/197 дугаар хамтарсан тушаал, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/30 тушаал, даатгуулагч / иргэн /-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход ашиглах 2021 оны гарын авлага, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2021 оны 67 дугаар тогтоолын хавсралт зэрэг эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг мөрдөн, Эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын саналыг үндэслэн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, сунгах болон хөдөлмөрийн нөхцөл солих зэргээр магадлан шийдвэрлэж байна.

2023 оны байдлаар Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нийт 48 удаа хуралдаж 2061 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг шийдвэрлэлээ. Үүнд:

№	Хөдөлмөрийн чадвар алдалтын магадлалаар	Тоо
1	Анх тогтоосон	305
2	Сунгасан	1598
3	Цуцалсан	97
4	Шилжиж явсан	41
	Шилжиж ирсэн	7
5	Хөдөлмөрийн нөхцөл сольсон	-
6	Нас барсан	13
7	Нийт хуралдсан тоо	48

Цуцалсан иргэдийг тоон үзүүлэлтээр нарийвчлан харуулбал:

№	Цуцалсан шалтгаан	Тоо
1	Өндөр насны тэтгэвэрт	29
2	Эрхтэн системийн үйл ажиллагаа тогтворжсон	17
3	Өөрийн хүсэлтээр	1
4	6 сараас дээш хугацаагаар сунгуулаагүй	7
5	Заалтгүй	15
6	Хяналтын хугацаа дууссан /хяналтгүй/	16
7	Бусад	0
8	Дахин магадлан	8
9	Нас барсан	13

Нийт хурлын ирц: Чингэлтэй дүүргийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 10 гишүүдээс нийт хуралд 100-80 (ЭХМК-ын 8-10 гишүүн) хувийн ирцтэй хуралдаж байна. Магадлагч эмч, ХБИ төлөөлөл нь өөрийн хүсэлтээр ажлаасаа гарсан. Одоогоор орон тоогоор ажиллахгүй байна.



Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, хянах, тогтоох, олгох ажлыг зохион байгуулж, 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар дараах цахим болон цаасан тэтгэмжийн хянаж, хуулийн хугацаанд олгож ажилласан. Үүнд:

1	Цахимаар илгээсэн тэтгэмжийн хянасан тоо	ХЧТА	10245
		ЖА	3210
2	Цаасаар илгээсэн тэтгэмжийн хянасан тоо	ХЧТА	2136
		ЖА	984
Бүгд		ХЧТА	12381
		ЖА	4194

Эмнэлэг хяналтын хурал болон ЭХМК-ын хурлын үеэр Засгийн газрын 2021 оны 67-р тоот тогтоолоор баталсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шинэчилсэн дүрэм” болон эмнэлгийн хуудасны шинэчилсэн А/38 журам, дээд газрын тушаал шийдвэр, чиглэлийг танилцуулан сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөг удаа дараа өгч ажилласан.

Нийт хороодын иргэдийн өвчлөл ХЧА-ын хувь хэмжээ өндөр байгаатай холбогдуулан өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллага, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, ЭХМК-ын эмч нартай хамтран ажиллаж иргэд (даатгуулагч), өрхийн эрүүлийн мэндийн төвийн эмч, нарийн мэргэжлийн эмч нарт ажлын

байрны сургалт болон мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх ажлыг тогтмолжуулан ажиллаж байна. Эмнэлэг хяналтын хурлын үеэр шинэчилсэн журам болон дээд газрын тушаал шийдвэр, чиглэлийг танилцуулан сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөг удаа дараа өгч ажилласан.

Хугацаагүй тогтоолгосон ХБИ-ийн мэдээллийг ЭХМК-ын программ, Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ЭМБ-ын бүртгэл болон программ, хур системтэй тулган шалгалаж тухай бүрт шийдвэрлэж байна.

2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс”-ын хурал зохион байгууллаа. Хурлын үеэр Эмнэлэг хөдөлмөр магадлалын үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалт тогтооход тулгамдаж буй асуудал, мэргэжлийн ур чадвар, харьцаа хандлага, иргэн (даатгуулагч)-д үзүүлэх эмнэлэг хөдөлмөр магадлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг хэлэлцэж, цаашид зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харилцан санал солилцлоо. Хуралд Чингэлтэй дүүргийн Нийгмийн Хөгжлийн хэлтсийн дарга, Чингэлтэй Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, ЧДЭМТ-ийн дарга, ЭХМК-ын гишүүд, Дүүргийн ЭМТ-ийн нарийн мэргэжлийн эмч нар, ӨЭМТ-ийн дарга нарын төлөөлөл оролцов.



2.5. Албан хэрэг хөтлөлтийн ажлын хүрээнд

Ирсэн бичиг болон явуулсан бичиг, өргөдөл, гомдлыг цаасан суурьтайгаар болон Абле, Edoc программаар цахимаар хүлээн авч хэлтсийн удирдлагад танилцуулан холбогдох тасгийн дарга, мэргэжилтнүүдэд хуулийн хугацаанд шилжүүлэн шийдвэрлүүлж ажиллаж байна.

Хэлтсийн удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, шийдвэрлэлтэд анхаарч албан бичиг шийдвэрлэх явцад хугацаа хэтэрсэн болон шийдвэрлэх процесст саад учирсан тохиолдолд хэлтсийн даргад танилцуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Абле программаар НДЕГ болон дотоод байгууллагаас ирсэн нийт өргөдөл, гомдол 1127 ирж хуулийн хугацаанд шийдвэрлэж, албан бичгээс хариутай 619 бичгийг шийдвэрлэсэн. Мөн Абле программаар 467 албан бичиг, хүсэлтийг холбогдох байгууллагууд руу хүргүүлэв.

Edoc программаар нийт 1963 албан бичгийг цаг тухайд нь шийдвэрлэсэн ба 67 бичиг хяналтын шатанд байна. Тус хэлтэс нь тайлант хугацаанд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой нийт 698 бичгийг Edoc программ ашиглан явуулсан. Ирсэн бичгийг тасгийн дарга хугацаа хэтэрч шилжүүлсэн буюу шийдвэрлэх хугацааны зөрчилтэй 4 албан бичиг байна.



chingeltei@ndaatgal.mn цахим хаягаар иргэд албан байгууллагаас 423 гаруй албан бичиг хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд тус хэлтсийн албан хаагчид болон иргэд аж ахуй нэгж байгууллагаас ирсэн нийт 3709 өргөдлийг Абле, Edoc программаар хүлээн авч, холбогдох хавсралт нотлох баримтуудыг шалган бүртгэл хөтлөн, хэлтсийн даргаар цохуулж, холбогдох ажилтанд шилжүүлж, нийт 3572 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлэн хяналт тавьж, хариуг иргэнд бичгээр болон утсаар мөн шуудангаар хүргүүлэн ба улирал бүр тайлан, мэдээг гаргаж ЧДЗДТГ, ННДГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Ажлын байран дээрх эмх цэгц үйлчилгээний стандартыг хэвшүүлэх зорилгоор НДЕГ-аас хэвлэн гаргасан “Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний гарын авлага” номыг хэлтсийн нийт албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн MNS 5140-1:2011, MNS 5140-3:2011 стандарт, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” журмын дагуу үйлдэгдэж Нийслэлийн Архивын газрын дарга цаасан суурьтай баримт бичгийг тайлант хугацаанд архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.

Авлигын эсрэг хуулийн 18.4.10-т заасны дагуу болон хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргийн хүрээнд байгууллага болон хувь хүний нууцыг бусдад задруулахгүй байх үүргийг сахин биелүүлж нууцын баталгаа гарган ажиллаж байна. Абле программаар НДЕГ болон дотоод байгууллагаас ирсэн нийт 405 албан бичгээс хариутай албан бичиг 204 үүнээс шийдвэрлэсэн нь 163 хяналтын шатанд 41, хариугүй албан бичиг 201 үүнээс шийдвэрлэсэн нь 52 байна. Абле программаар 312 албан бичиг, хүсэлтийг холбогдох байгууллагууд руу хүргүүлэв. Edoc программаар нийт 1122 албан бичгийн хариуг хугацаанд шийдвэрлэсэн ба 50 бичиг хяналтын шатанд байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой тоон гарын үсэг ашиглан 329 албан бичгийг хариуцах байгууллага руу шилжүүлсэн байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлийн мэдээг улирал бүр нийт албан хаагчдад танилцуулж, зөрчил гаргасан албан хаагчдад сануулах арга хэмжээг тухай бүр нь авч ажиллаж байна.

Хэлтсийн үйлчилгээний чанар болон өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийх талаар судалж, цаашид нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах, зорилготой 2023 оны 10 дугаар сарын 19-31 хооронд нэг цэг дээр үйлчилгээ авсан даатгуулагч иргэдээс судалгаа авч цаашид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой ажил сайжруулах төлөвлөгөө гарган үйлчилгээний чанарыг байнга сайжруулж ажиллаж байна.

Нийт өргөдөл гомдлын ихэнхи хувийг тэтгэврийн даатгал эзлэж байгаа бөгөөд энэ нь Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолтод өөрчлөлт оруулах тухай, Тэтгэвэрийн хэмжээг өөрчлөлт оруулах тухай”, тогтоолыг хэрэгжүүлсэнтэй холбоотой.

2.6.Архивын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд 2654 нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа олгон, хүсэлт явуулсан. Үүнээс ABLE программаар 379 лавлагаа авах хүсэлт явуулж, 232 хүсэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. 1990-2000 нөхөн даатгалын тодорхойлолт 261, 1992-1994 оны тодорхойлолт 190, ЧД-ийн Цагдаагийн 1, 2-р хэлтсээс нийт 196, 1995-2005 оны 1221 лавлагаа, шимтгэл төлдөггүй 172 лавлагаа, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй тодорхойлолт 192, эрх үүссэн тодорхойлолт 15-г тухай бүр үндсэн баримттай тулгаж архивын лавлагаа, тодорхойлолт гарган ажилласан.



Able-аар ирсэн хүсэлт болон явуулсан хүсэлт:

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДШ-ийн лавлагаа авахаар ирүүлсэн хүсэлтийн тоо					
Нийслэлийн дүүрэг	тоо	Аймаг	тоо	Аймаг	тоо
Баянзүрх	51	Баян-өлгий	0	Орхон	23
Баянгол	77	Баянхонгор	8	Төв	22
Сүхбаатар	34	Булган	5	Дорноговь	3
Сонгинохайрхан	45	Архангай	5	Өмнөговь	3
Хан уул	49	Говь-алтай	10	Хэнтий	3
Багануур	8	Говьсүмбэр	0	Сэлэнгэ	12
Налайх	1	Дархан	22	Хөвсгөл	2
Багахангай	4	Өвөрхангай	12	Увс	10
Дундговь	3	Дорнод	4	Ховд	4
		Завхан	15		
Нийт			435		
Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДШ-ийн лавлагаа авахаар хүргүүлсэн хүсэлтийн тоо					
Нийслэлийн дүүрэг	тоо	Аймаг	тоо	Аймаг	тоо
Баянзүрх	26	Баян-өлгий	0	Орхон	10
Баянгол	41	Баянхонгор	3	Төв	18
Сүхбаатар	44	Булган	3	Дорноговь	2
Сонгинохайрхан	41	Архангай	7	Өмнөговь	4
Хан уул	32	Говь-алтай	11	Хэнтий	4
Багануур	8	Говьсүмбэр	1	Сэлэнгэ	13
Налайх	0	Дархан	22	Хөвсгөл	2
Багахангай	2	Өвөрхангай	13	Увс	18
Дундговь	2	Дорнод	4	Ховд	4
		Завхан	12		
Нийт			379		

НДЕГ-ын даргын 2022 оны А/22 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагаас олгож буй шимтгэл төлөлтийн лавлагааг үнэ төлбөргүй байхаар шийдвэрлэсэн.

Тус хэлтэс нь ажил олгогч, иргэд даатгуулагчдад шимтгэл төлөлтийн болон бусад лавлагаа, тодорхойлолтыг үнэ төлбөргүй, цахимаар авах боломжийг бүрдүүлж, мэдээллээр ханган, холбогдох лавлагаа, тодорхойлолтыг Е-Монголиа, ТҮЦ машин, гар утасны аппликейшн ашиглан авах талаар мэдээлэл сургалт, сурталчилгаа тогтмол өгч, 2006 оноос хойшхи QR код бүхий архивын лавлагааг заавар журмын дагуу харьяалал харгалзахгүй, үнэ төлбөргүй, түргэн шуурхай гаргаж байна.

2023 онд хэлтсийн даргын баталсан хуваарь, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдаас 2022 оны архивын баримтыг стандартын дагуу шалган хүлээн авсан.

2023 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж, Түр хадгалах хадгаламжийн нэгж бүхий **нийт 1016** баримтуудыг ХХНЖ-тай тулган бүртгэлжүүлж, дугаар өгч, нягтруулсан шүүгээнд байршуулсан.


Хэлтсийн архивд 11 төрлийн бүртгэл бүхий нийт 7069 гаруй хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Архивт хадгалагдаж байгаа 1992-2021 оны бүх баримтуудыг ХХНЖ-ын дагуу нэг бүрчлэн дугаарлаж, нягтруулсан шүүгээнд хайрцаглан байршуулсан.

Хэлтсийн архив нь өрөө тасалгааны хүрэлцээ муу, зай талбай багатай учир лавлагаанд байнга гардаг, байцаагч, албан хаагчид, нягтлан бодогч нарт албан хэрэгцээнд шаардлагатай баримтууд, 1998-2021 оны байнга хадгалах 558 хадгаламжийн нэгж, 2008-2021 оны түр хадгалах 2678 хадгаламжийн нэгж, 1994-2018 оны 70 жил хадгалах 7098

хадгаламжийн нэгж, 1994-2018 оны 70 жил хадгалах нд орлогын харилцахын баримт 635 хадгаламжийн нэгж, 1995-2018 оны Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан 4946 хадгаламжийн нэгж, 1995-2018 оны 70 жил хадгалах Сайн дурын даатгалын хувийн хэрэг 58 хадгаламжийн нэгж тус тус хэлтсийн архивт хадгалагдаж байна.

Хайлааст дахь тасгийн архивт 1994-2017 оны нийт 4 төрлийн бүртгэл бүхий 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийг эмхлэн цэгцэлж, нягтруулсан шүүгээнд бүртгэлийн дагуу байршуулсан бөгөөд 2008-2017 оны түр хадгалах сангийн зарлагын харилцахын баримт, 70 жил хадгалах 1994-2007 оны сангийн орлого зарлагын харилцахын баримт, 2012-2018 оны 70 жил хадгалах ажилгүйдлийн хувийн хэрэг, мөн 2012-2016 оны нөхөн даатгалд хамрагдсан иргэдийн баримт тус тус хадгалагдаж байна



Дотоод албан хэрэгцээнд 477 хадгаламжийн нэгж бүхий баримтыг албан хаагчдад ашиглуулан бүртгэл хөтөлсөн.

Архивын баримтын хадгалалт хамгаалалтад хяналт тавих зорилгоор Хадгаламжийн сангийн чийг, дулаан хэмжилтийн бүртгэлийн дэвтэр хөтөлж 7 хоногт 5 удаа чийг дулааныг хэмжин ажиллаж байна.

2023 оны 3 сарын 22-ны өдөр ЧДЗДТГ-аас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт, анхаарах асуудлууд, Тоон гарын үсэг ашиглан албан бичиг боловсруулах нь” сэдэвт багц сургалтад тус хэлтсийн Орлого шимтгэлийн тасгийн дарга, архивын ажилтан нар хамрагдаж, нийт албан хаагчид дотооддоо сургалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг шалгалтанд бэлтгэл хангах зорилгоор ажилласан тайланг тавигдах шаардлага үзүүлэлтийн дагуу гаргасан.

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйл, 23.2.1, 23.4, 23.2.9, 27.1, 24.1, 25.1, 25.2 дахь заалтын хэрэгжилт.

- Албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримтыг ажилтнаас бүрэн бүрдэлтэй хүлээн авч хэвшсэн.

- Архивын орон тооны ажилтантай
- Архивын баримтыг хугацаанд нь харьяалах архивд шилжүүлсэн
- Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлсэн
- Архивд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийг шийдвэрлэсэн.

Хэлтсийн даргын 2022 оны А, Б тушаалуудыг archive.edoc.mn цахим санд нийт 12690 хуудас баримт оруулж, дүүргийн Архивын тасагт болон Нийслэлийн архивын санд нягтлан шалгалт хийж дууссан.

Архивын сан хөмрөгт цаасан баримтын тооллого хэсэгчилэн хийж, дахин боловсруулах баримтын хязгаарыг 2008-2021 оны заагаар тогтоож, данс бүртгэлтэй тулгалт

хийж Түр хадгалах баримтаас хадгалах хугацаа нь дууссан нийт 312 хадгаламжийн нэгжийг ялган авч устгалд бүртгэн авсан.

Мөн лавлагаанд тогтмол гарах шаардлагагүй 156 хадгаламжийн нэгжийг Хайлаастын салбарт архивын хөмрөг хадгалах өрөөнд шилжүүлэн байршуулсан.

БНШК-оор 8 удаа хурал зохион байгуулж, 32 хэлэлцүүлэх асуудлуудаа комиссын дарга болон гишүүдэд урдчилан танилцуулж шийдвэрлүүлсэн. Үүнд:

- Хурлын комисс шинэчлэн Комиссын дүрэмд нэмэлт оруулан тушаалын хавсралтаар батлагдсан.
- Устгах хэргийн актыг үүсгэн данс бүртгэл үйлдэн нийт 20 хэргийн 314 хадгаламжийн нэгж танилцуулж комиссын 4 дүгээр хурлаар шийдвэрлүүлсэн.
- ХХНЖ-ыг салбарын үлгэрчилсэн жагсаалттай уялдуулах санал боловсруулан 2 удаа комиссын хуралд хэлэлцүүлэн танилцуулсан.
- 2008-2018 оны байгууллага дээр Түр хадгалах хадгаламжийн нэгжүүдийн батлан шалгалт хийж шинэчилсэн данс үүсгэн 20 хэргийн 1473 хадгаламжийн нэгж танилцуулан 04 дэх комиссын хурлаар баталгаажуулсан.
- 2019-2021 оны Түр хадгалах баримтаар 20 хэргийн 943 хадгаламжийн нэгжээр данс бүртгэл үүсгэн 04 дүгээр комиссын хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан.

2023 онд хэлтсийн даргын баталсан хуваарь, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдаас 2022 оны архивын баримтыг стандартын дагуу шалган хүлээн авсан.

2023 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж, Түр хадгалах хадгаламжийн нэгж бүхий нийт 1016 баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалттай тулган бүртгэлжүүлж, дугаар өгч, нягтруулсан шүүгээнд байршуулсан.

Хэлтсийн архивт 11 төрлийн бүртгэл бүхий нийт 4016 гаруй хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Архивт хадгалагдаж байгаа 1992-2021 оны бүх баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу нэг бүрчлэн дугаарлаж, нягтруулсан шүүгээнд хайрцаглан байршуулсан.

Хайлааст дахь тасгийн архивт 1994-2017 оны нийт 4 төрлийн бүртгэл бүхий 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийг эмхлэн цэгцэлж, нягтруулсан шүүгээнд бүртгэлийн дагуу байршуулсан бөгөөд 2008-2017 оны түр хадгалах сангийн зарлагын харилцахын баримт, 70 жил хадгалах 1994-2007 оны сангийн орлого зарлагын харилцахын баримт, 2012-2018 оны 70 жил хадгалах ажилгүйдлийн хувийн хэрэг, мөн 2012-2016 оны нөхөн даатгалд хамрагдсан иргэдийн баримт тус тус хадгалагдаж байна. Архивын баримтын хадгалалт хамгаалалтад хяналт тавих зорилгоор Хадгаламжийн сангийн чийг, дулаан хэмжилтийн бүртгэлийн дэвтэр хөтөлж 7 хоногт 5 удаа чийг дулааныг хэмжин ажиллаж байна. Мөн лавлагаанд тогтмол гарах шаардлагагүй 156 хадгаламжийн нэгжийг Хайлаастын салбарт архивын хөмрөг хадгалах өрөөнд шилжүүлэн байршуулсан. 2023 оны 09 дүгээр сарын 09-нд Хэлтсийн архивын өрөөнд засварын ажил хийгдсэн.



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар “Архивын тухай”, Байгууллагын Архивын ажиллагааны нийтлэг журмын

дагуу “Байгууллагын Архивын гэрчилгээ” авах танилцуулга бэлдэж хурлаар орсон. Мөн “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын” 2.8, 2.9, 2.10, 6.7 дах заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллаж, Архивын байр, өрөөний талаар Онцгой байдлын дүгнэлт гарган авч ажилласан.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

3.1 Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд

Тус хэлтэс нь Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлэх явцад ажил үйлчилгээнд гарч байгаа алдаа зөрчил, иргэд даатгуулагчдаас ирж байгаа өргөдөл гомдлыг чирэгдэлгүй, шуурхай шийдвэрлэх, төрийн үйлчилгээний төгөлдөршилийг бий болгох зорилгоор Чанарын менежментийн тогтоолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэлтсийн даргын 2021 оны 10 сарын 11-ний өдрийн А/44 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө боловсруулж, хэлтсийн нийт албан хаагчдыг үүрэгдүүлэн, стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Стандарт хэмжил зүйн үндэсний төвд хүсэлт гарган 2023 оны 05 дугаар сарын 23-24 -ний өдөр тус төвийн мэргэжилтэн аудитор н.Чимгээ, аудитор Г.Алтанцэцэг нар хоёр өдрийн хугацаанд хөндлөнгийн аудит хийж, стандарт хэмжил зүйг тодорхойлох, чанарын зорилт биелэлт, эрсдэлийн төлөвлөгөө, удирдлагын дүн шинжилгээнд тулгуурлан дүрэм журам хуулийн зохицуулалт нийт 8 бүлэг дээр дотоод аудит хийж баталгаажуулахаар ажиллаж байна.



Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Удирдлагын баг болон хэлтсийн нийт албан хаагчдад чиглүүлэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Тус төслийн хүрээнд 4 байцаагч ажилтныг гэрчилгээжүүлж сургаалтанд хамруулсан.





Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус хэлтэс нь Орлого шимтгэлийн тасаг-6, Үйлчилгээний тасаг-7, Хяналт шалгалт дотоод аудитын тасаг-7, Санхүү бүртгэлийн тасаг -9 нийт 29 ажлын зааврыг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэд даатгуулагчдаас хүлээн авах өргөдлийн маягтыг боловсруулан баталж, батлагдсан маягтын дагуу өргөдлийг хүлээн авч хэвшсэн.

Мөн чанарын гарын авлага боловсруулж стандарт хэмжил зүйн үндэсний газрын тохирлын гэрчилгээ авахад удирдлагын дүн шинжилгээ болон бусад ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. ISO 9001:2015 стандарт хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагчдыг идэвхижүүлэх, эерэг уур амьсгал бий болгох зорилгоор ажил эхлэхээс өмнө өглөө бүр 7.40-7.50 цагийн хооронд дасгал хөдөлгөөнийг идэвхитэй хийж, “Эрхэм зорилго, Чанарын бодлого”-ыг зэргийг өглөө бүр хэлж, ажлаа эхлүүлэх зэргээр нийт албан хаагчдыг оролцуулан эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэн ажиллаж байна. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаандаа ашиглах журамуудыг боловсруулж, 5S стандартыг баталж, процессын зураглал хийж ажилласан.

“ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС” нь ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ГЭРЧИЛГЭЭГЭЭ ГАРДАН авч Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлэн төрийн үйлчилгээний төгөлдөршилийг бий болгох зорилгоор Олон улсын “Чанарын менежментийн тогтоолцоо ISO 9001:2015” стандартыг 2021 оноос эхлэн үйлчилгээний чанар, хүртээмж, сэтгэл ханамжийн цогц систем бүхий үйлчилгээг байнга нэвтрүүлэн хэрэгжүүлж байсан. Энэ ажлын хүрээнд технологийн шинэчлэлээр хязгаарлагдахгүй цаашид удирдлага, хяналтын тогтолцоог илүү өндөр үр ашигтай, оновчтой зохион байгуулах менежментийн чадавхыг бэхжүүлэн иргэд даатгуулагчдынхаа сэтгэл ханамжийг байнга дээшлүүлж, нийгмийн даатгалын салбарт хувь нэмрээ нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж байна. ISO 9001:2015 төсөл байгууллагаараа суралцах боломжийг олгож, тасралтгүй сайжруулалтын ухамсар, хандлагыг дээшлүүлж өгсөн гэдэгт бид итгэлтэй байна. Бид Чанарын удирдлагын тогтолцооны үндэс суурийг баттай тавин Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн IAF баталгаажуулалтад тэнцэж, салбарынхаа хөгжлийн түүхэнд дахин шинэ амжилтыг авчирч ажиллаж байна





3.2 Хамтран ажиллах уулзалт зохион байгуулж ажиллах ажлын хүрээнд

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Непал Улсын Үндэсний бүтээмжийн төвийн төлөөлөгч, эдийн засгийн хөгжлийн төв (ҮБЭЗХТ) болон Аж үйлдвэр, худалдаа, хангамжийн Яамны (АҮХХЯ) удирдлагын төлөөлөгчид Тус хэлтсийн үйл ажиллагаа Ухаалаг ажлын байр төсөл, Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын хэрэгжилттэй танилцан уулзалт туршлага солилцох ажиллалаа.



Монголын бүтээмжийн төв (МБТ) нь Олон Улсын Засгийн газар хоорондын байгууллага болох Азийн Бүтээмжийн Байгууллага /АББ/-д 1992 оноос хойш Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, аж ахуйн нэгжийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор АББ болон бусад гишүүн орнуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гишүүн орнуудад зохион байгуулагдах сургалтад Монгол Улсаас төлөөлөгч хамруулах, АББ-ын сургалт, арга хэмжээг өөрийн оронд жил бүр зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Энэ үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс Монголын бүтээмжийн төвтэй 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 09/23 тоот Хамтран ажиллах байгуулж ажилласан. Гэрээний дагуу Монгол улсын засгийн газрын 265 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан Монголын бүтээмжийн төвтэй хамтран шат дараалсан бүтээмж дээшлүүлэх, чанар сайжруулах сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна.

“Үйлчилгээний төгөлдөршил” тогтолцоо сайжруулалтын цогц хөтөлбөр нь байгууллагын менежментийн тогтолцоо болон процессыг тасралтгүйгээр сайжруулж, бэхжүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлж, сонирхогч талуудад илүү их үнэ цэнийг бий болгоход чухал ач холбогдолтой юм. Төрийн байгууллагын төгөлдөршил нь байгууллагын менежментийн тогтолцоо гэхээс илүүтэйгээр хийж буй бүх зүйлээ (үүнд манлайлал,



стратеги, хэрэглэгч даатгуулагч, мэдлэгийн менежмент, хүн хүч, процесс, үр дүн гэсэн үндсэн 7-н талбарыг хамарна) төгс төгөлдөр түвшинд гүйцэтгэж, улмаар хамгийн сайн үйлчилгээний үр дүнд хүрэхийг хэлнэ.

Аливаа байгууллагын үйл ажиллагааг төгөлдөршүүлэх нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад түргэн хариу үзүүлэх, байгууллагын мэдээлэлд дүн шинжилгээ хийж шийдвэр гаргалтыг сайжруулах, мэдлэг хуваалцах таатай орчныг бүрдүүлэх, үйл ажиллагааг баримтжуулах замаар тасралтгүй сайжруулах тогтолцоог бий болгоход чухал нөлөөтэй. Иймд төслийн хүрээнд үйлчилгээний төгөлдөршлийн тогтолцооны дагуу дотоод үнэлгээг хийх, түүнд дүн шинжилгээ хийж, цаашдын сайжруулалт хийх алхмуудыг тодорхойлох замаар бүтээмж, чанарыг дээшлүүлэх үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлэхэд чиглэгдэж хэлтсийн үйлчилгээ болон даатгуулагчдад чиглэсэн судалгаа шинжилгээ дүгнэлтүүд дээр тулгуурлан ажиллаж байна.

3.2 Санхүү бүртгэлийн ажлын хүрээнд

Тус хэлтэс нь Монгол улсын нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд иргэдэд тэтгэвэр, тэтгэмж олгох асуудлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа.

2023 оны 4 улирлын нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт

2023 оны 4 улирлын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сан тус бүрээр биелүүлж нийт дүнгээр 137,6 %-иар давуулан биелүүлсэн.

<i>/сая төгрөгөөр/</i>				
№	Нийт орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Нийт шимтгэлийн орлого	464714,4	532809,1	114,6
2	Сайн дурын даатгалын шимтгэл	9787,8	6441,2	65,8
3	Бусад орлого	620,1	8605,9	165,8
	Нийт дүн	475122,3	547856,2	115,3

Банкнудаар хийгдсэн сангийн орлого зарлагын гүйлгээний талаар:

1. Монгол улсын Сангийн сайд, Хөдөлмөр Нийгэм хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/А/245 тоот хамтарсан тушаалаар баталсан “Маягт журам батлах тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/65 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”ийг тус тус мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна.

2. Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкаар орж ирсэн сайн дурын болон ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээллийг банкны хуулгатай тулган төвлөрсөн харилцахын мэдээллийн санг бүрдүүлсэн.

3. Сайн дурын 1100 даатгуулагчийн 27,2 сая төгрөгийн алдангийг шимтгэлийн орлогоос салган бүртгэж 3 санд хуваарилан ажиллав.

4. Сайн дурын болон бусад даатгуулагч 686 ээжүүдийн сар бүр төлсөн шимтгэлийг шалган, сайн дурын даатгалын шимтгэлээс салган тэтгэмж болон улсын төсөв ээжүүдийн бүртгэлд оруулан ажилласан.

5. Нэр, регистр тодорхойгүй 284 гүйлгээг банкны данс эзэмшигчийн жагсаалт болон мэдээллийн сангаас олох, банкинд жагсаалт хүргүүлэн мэдээлэл солилцох ажлын хүрээнд 472,8 сая төгрөгийг ажил олгогч ба даатгуулагчийн нэр дээр залруулан бүртгэж мэдээллийн санг үнэн зөв болголоо.



6. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар торгуулийн орлого 4,0 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогын 5 сангийн эзлэх хувиар хуваарилсан.

7. 4 дүгээр улирлын байдлаар арилжааны банкуудаас харилцахын чөлөөт үлдэгдэлд тооцох хүүг “Хамтран ажиллах гэрээ”-нд заасны дагуу Капитрон, ХААН, Голомт, Худалдаа хөгжлийн банкууд 2023 оны 2 дугаар сарын 1-нээс, Төрийн банк 2023 оны 4 дүгээр сарын 14-нээс эхлэн хүүг тооцож олгож байна. Харилцахын үлдэгдэлд тооцсон хүүгийн орлогод 124,8 сая төгрөгийг тооцоо нийлэн холбогдох сангийн харилцах дансуудад төвлөрүүлэн ажиллалаа.

8. Арилжааны банкаар гаргаж буй гүйлгээг батлагдсан журмын дагуу бүртгэлтэй Email хаягаараа дамжуулан хийж байна. НДЕГ-тай байгуулсан арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу эхний хагас жилийн гэрээг дүгнэн ажиллалаа.

№	Банк	Гүйлгээний тоо /сарын дундаж/	Орлогын дүн /сая төгрөгөөр/	Зарлагын дүн /сая төгрөгөөр/
1	Төрийн сан	4872	111016,6	109752,7
2	Төрийн банк	27708	372585,0	370233,9
3	Төрийн банк /ЭМД/	389	5592,7	5589,6
4	Худалдаа хөгжлийн банк	2856	203903,4	203871,8
5	Капитрон	9277	13356,4	13514,9
6	Капитрон /ЭМД/	2766	325,3	325,9
7	Хаан	27821	309079,8	303648,7
8	Голомт	6607	209452,3	209445,6
Нийт дүн		82296	1225311,5	1216383,1

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд арилжааны банкнуудаас ирсэн төвлөрсөн сангийн хуулгыг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 2-ны өдөр цаг хугацаанд нь үнэн зөв гарган цахимаар хүргэн ажиллав.

Илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг даатгуулагч тус бүрээр хянаж, 103 хүнд 246,5 сая төгрөгийн буцаан олголтыг олгож, холбогдох дансдуудад хуваарилалт хийсэн.

Дүүрэг хоорондын данс андуурсан ажил олгогч, даатгуулагчийн 97,9 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн залруулж, байгууллагын нэр регистр зөрсөн 58,2 сая төгрөгийн гүйлгээг утасны дугаар, дансыг ашиглан холбогдон залруулж өглөг, авлага гаргахгүй байх тал дээр анхааран ажиллалаа.

2023 оны 1 дүгээр улирлаас эхлэн төсөвт байгууллагууд бүх төрлийн гүйлгээг “Санхүүгийн нэгдсэн нэвтрэлтийн систем”-д холбогдсноор өөрийн байгууллага дээр үүссэн нэхэмжлэх, И баримт зэргийг татаж авч гүйлгээг хийдэг болсон нь ихээхэн ажил хөнгөвчилсөн, цаг хугацаа хэмнэсэн, үр дүнтэй шинэлэг ажил болсон байна.

Нийгмийн даатгалын сангийн бүх төрлийн дансуудаас цахимаар гүйлгээ хийхдээ төвлөрсөн орлогын дансыг буруу сонгосноос залруулгын гүйлгээ нилээд их гарч байгааг залруулж, Чингэлтэй дүүргийн НДХэлтсийн пэйж хуудсан дээр харилцах дансны дугаарыгн жагсаалтыг шинэчлэн тавьж, ажил олгогч байгууллагуудын ня-бо нарт заавар зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцсан, ажил олгогчоос давхардуулан төлсөн 21,6 сая төгрөгийн гүйлгээг өргөдлийн дагуу залруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон илүү төлсөн шимтгэлийн буцаалт 38,6 сая төгрөгийг ЭМДЕГ-с нэхэмжлэн ажиллаж байна.

Даатгалын сангуудаас иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж олгох ажлын хүрээнд:



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Анхан шатны баримтыг үндэслэн ажил олгогч, даатгуулагчдад 6 банкны 45 харилцах дансаар нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон НББ-ийн хөтлөлт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт зарцуулалтанд бүртгэлээр хяналт тавьж, төвлөрсөн харилцах орлогын дансны хуулга болон тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдлийн тэтгэмжийг шилжүүлж, дансны хуулга, үлдэгдлийг тулган нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэн ажиллав.

Тэтгэмж, ҮОМШӨ даатгалын сангаас олгосон тэтгэмжийг төрөл тус бүрээр, ажилгүйдлийн сангаас олгосон тэтгэмжийг 2023 оны жилийн эцсийн байдлаар зарцуулалтыг харуулбал:

/сая төгрөгөөр/						
№	НД-ын сан	Гүйлгээний тоо	Даатгуулагчийн тоо	Сангийн зардлын төлөвлөгөө	Сангийн зардлын гүйцэтгэл	
1	Тэтгэвэр	6122	25247	188341,6	185012,6	
2	Тэтгэмж	ЖА	4908	4879	14208,6	14207,0
		ХЧТА	5465	11026	3740,4	3241,2
		Оршуулга	486	486	1258,0	1009,0
3	Ажилгүйдэл	3180	1459	4304,9	5532,5	
4	ҮОМШӨ	334	302	1364,7	1336,2	

Сангийн зардлаас ажилгүйдлийн даатгалын сангийн зардал хэтэрч байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар 1227,6 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй бөгөөд НДЕГ-ын Бодлогын Хэрэгжилт, Судалгааны Газарт төсөвт тодотгол хийлгэх саналаа хүргүүлэн ажиллаж байна.

Оршуулгын тэтгэмжийг орон нутгийн харьяалал харгалзахгүй олгож байгаагаас шалтгаалан төсөв хүрэлцэхгүй, тэтгэвэр, тэтгэмж давхардах, илүү олгогдох эрсдлүүд үүсэж байгаа талаар дээд газарт саналаа хүргүүлсэн.

4 дүгээр улирлын байдлаар тэтгэврийн зарцуулалтыг төрлөөр нь дэлгэрэнгүй харуулбал:

№	Тэтгэврийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Өндөр насны тэтгэвэр /тэт даатгалын сангаас/	150404,1	149200,7	1203,4	99,1
2	Тахир дутуугийн тэтгэвэр	14821,3	14056,0	765,3	94,8
3	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	6240,3	6114,6	125,7	97,9
4	Цэргийн тэтгэвэр	16875,9	15641,3	1234,6	92,6
Нийт дүн		188341,6	185012,6	3329,0	98,2
5	Тахир дутуугийн тэтгэвэр /үомшө даатгалын сангаас/	1030,7	961,2	69,5	93,2
6	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр /үомшө даатгалын сангаас/	150,4	135,1	15,3	89,8
Нийт дүн		1181,1	1096,3	84,8	92,8

Хуваарилалт, төвлөрүүлэлтийг сан тус бүрээр харуулбал:



Төвлөрсөн харилцахаас нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг холбогдох сангуудад ногдуулалтын хувийг үндэслэн 7 хоног бүр хуваариллаа. 2023 оны 4 улирлын байдлаар сан тус бүрийн хуваарилалт, төвлөрүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр /

№	НДШ орлого	тэтгэвэр	тэтгэмж	ҮОМШӨ	ЭМД	Ажилгүйдэл	ДҮН
1	АО байгууллагын санд хуваарилах %	70,28%	7.5%	4,51%	16,29%	1,42%	100%
2	СДД байгууллагын санд хуваарилах %	85.18%	7.41%	7.41%	0.00%	0.00%	100%
3	Акт төлбөрийн орлогын санд хуваарилах %	72,74%	7,55%	4,92%	1,21%	13,58%	100%
4	НИЙТ ХУВААРИЛАХ ДҮН	432614,8	43561,7	51322,2	93642,6	8682,5	629823,8
5	01-12 сард НДЕГ-т төвлөрүүлсэн	247602,2	23940,1	49986,0	93642,6	3150,0	418320,9

Сангийн бусад өглөг, авлагын талаар (1218, 3303 тоот данс)

Тэтгэвэр, тэтгэмжийн олголт жагсаалт файл бэлтгэх үед тухай банкны олгох тэтгэврийн сард олговол зохих дүнгээр бэлдсэн эсэхийг мөн тэтгэмжийн жагсаалтаар тухайн байгууллагын нэхэмжлэлийн дүн, дансны дугаар зөв эсэхийг тодруулж шалгасны дараа гүйлгээ гаргахыг сангийн нябо нарт анхааруулж хяналт тавин ажиллаж байна.

Улирал бүр тайланг шалгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулан шалгаж тайлангийн хаалтыг тухай бүрт нь хийж байна. Тайлант онд 1218 /бусад авлага/ дансны үлдэгдэл 156,4 сая төгрөг байснаас 1282,7 сая төгрөг авлагаар бүртгэгдэж 925,2 сая төгрөгийн авлагыг харилцах дансанд төвлөрүүлж 514,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны авлагаас 69,8 сая төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

2022 оноос эхлэн Улсын байцаагчийн акт тавигдаагүй НББ-ийн бүртгэлийн бичилтээр даатгуулагч иргэд болон ажил олгогчийн нэр дээр шууд авлага үүсгэж бүртгэхгүйгээр арилжааны банкуудад мэйл хаягаар хүснэгтийн дагуу нэр тодорхойгүй орлого, зарлагын гүйлгээг тодруулан тухай бүрт нь бүртгэлийг үнэн зөв хөтлөх талаар анхаарч ажиллаж байна. Бусад өглөг /3303/ дансны өглөг оны эхэнд 63,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 9,6 сая төгрөгийг бууруулж 54,2 сая төгрөгийн өглөгтэй байна. Цаашид дээрх дансуудад ташаарсан орлогоор бүртгэсэн гүйлгээг нэмэгдүүлэхгүй байх, тухайн үед нь залруулах чиглэлээр анхааран үлдэгдлийг бууруулах талаар дотооддоо төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Сарын мэдээ болон тайлангийн гарсны дараа шинжилгээ хийж, сан тус бүрийн зарлагын дүнг өмнөх сарынхаас өссөн буурсан зардлыг тэтгэвэр, тэтгэмж бодсон бүртгэл журналын бичилтийг тулган шалгаж байна.

Бусад өглөг /3303/ дансанд бүртгэгдсэн байгууллагын нэр, регистр тодорхойгүй гүйлгээнүүдийн жагсаалтыг харилцагч банкуудад EXCEL-ээр гаргаж хүргүүлэн нэр тодорхойгүй ажил олгогч даатгуулагчийн регистрийн дугаар, ажил олгогчийн код, утасны дугаар зэрэг мэдээлэл солилцох, даатгуулагч иргэдтэй утсаар холбогдож тухайн үед харилцах дансанд НДШ-ийн болон СДД-ийн шимтгэл төлсөн банкны хуулга, холбогдох баримтуудыг авч гүйлгээнүүдийг залруулан ажиллаж байна.



Илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмжийг төлүүлэхээр улсын байцаагчийн акт тавигдаж төлбөрийг харилцах дансанд төлүүлэх ажил гүйлгээг бусад авлага /1218/ дансаар бүртгэдэг.

Тухайн илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийн авлагыг сан тус бүрээр, байгууллага, хувь хүнээр нь салган бүртгэж байна.

Ажил олгогч байгуулагад ХЧТА-ны болон Жирэмсэн амаржсны тэтгэмж илүү олгогдсон тохиолдолд тухайн ажил олгогчоос авлагаар бүртгэлд тусгаж тооцоо нийлэн албан бичиг хүргүүлж харилцах дансанд төлүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцсан, ажил олгогчоос давхардуулан төлсөн 21,6 сая төгрөгийн гүйлгээг өргөдлийн дагуу залруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон илүү төлсөн шимтгэлийн буцаалт 38,6 сая төгрөгийг ЭМДЕГ-с нэхэмжлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны зардлын төсөв болон гүйцэтгэлийн талаар

2023 оны хэлтсийн үйл ажиллагааны зардлын батлагдсан тодотгосон төсвийн дагуу 1573,6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын төсвийг сар бүр зориулалт, хөтөлбөр арга хэмжээний дагуу зарцуулан ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар цалин хөлсөнд 830,2 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 103,5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43,5 сая төгрөг зарцуулж бусад зардлуудыг төсвийн зардлын зүйл ангид тусгасны дагуу зарцуулан ажиллаж байна.

Тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 53,1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд төсвийн сахилга батыг чанд хатуу баримтлан ажиллаж байна.

Капитрон банкны түрээсийн гэрээг цаг хугацаанд нь сунгаж түрээсийн төлбөрийг тухай бүрт нь НДЕГ холбогдох дансанд төвлөрүүлэн ажиллаж байна

Нийгмийн даатгалын сангийн орлогын болон Хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны дунд хугацааны төсөөллийн саналыг Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд батлагдсан зааврын дагуу боловсруулж Нийслэлийн нийгмийн даатгалын газарт 2023 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн дотор хүргүүллээ.

2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны дунд хугацааны төсөөллийн саналыг боловсруулахдаа цалингийн сангийн өсөлт, ажил олгогч даатгуулагчдын хамралт, өсөлт, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын тооцоо, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдлээс 30 хувиар барагдуулах зэрэг гол үзүүлэлтүүдийн тооцооллыг оруулан боловсруулж ажиллалаа.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт

Хэлтсийн даргын 2022 оны А/59 тоот тушаалаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих ажилтнуудын ажил үүргийн хуваарийг шинэчлэн мэдээ, мэдээллийг байршуулах, олон нийтэд хүргэх, сайтанд байршуулсан мэдээллийг хянах, ажлын дүн мэдээг гаргах зэргээр шинэчлэн баталсан. Шилэн дансны мэдээ, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан үндэслэлээр 2022 оны тайлангаар аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

2023 оны эхнээс шилэн дансны сайт шинэчлэгдсэн бөгөөд хуучин программаас мэдээ, мэдээллүүдийг шинэчилж оруулсан. Сар бүрийн мэдээ, улирал, жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, орлого зарлагын гүйлгээ зэргийг www.shilendans.gov.mn сайтад байршуулан нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллаж байна.



Хэлтсийн мэдээллийн самбарт сар бүрийн санхүүгийн мэдээг тогтмол шинэчлэн байршуулж хэвшүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй, хуулийн хугацаанд нийтдээ 32 нэр төрлийн мэдээ мэдээллийг шилэн дансны сайтад байршуулан ажиллаж байна. Шилэн дансны мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байршуулсныг хяналт тавих, дүн шинжилгээ хийх ажлыг Хяналт шалгалт дотоод аудитын тасгаас байнга хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын байгууллагын дүгнэлтийн биелэлт, хэрэгжилт

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд “ЦЭБЭ Консалтинг Аудит” ХХК аудитын шалгалт хийж, аудитын байгууллагад шаардлагатай тоон мэдээлэл, судалгаа, байгууллагын үйл ажиллагаа, удирдлага хяналтын системийн талаар мэдээллүүдийг хүргүүлэн ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 оны Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Өөрчлөлтгүй гэсэн дүгнэлт гаргаж, 3 төрлийн зөвлөмж өгсөн.

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн мөрөөр дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар ирүүлсэн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж батлуулсаны дагуу хэлтсийн бүх ажилтан, албан хаагчдад хуулийг сурталчлан таниулах, зардлыг зүйл зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд нэг мөр ойлголт өгөх зорилгоор сургалт зохион байгууллаа.

3. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй, хуулийн хугацаанд нийтдээ 32 нэр төрлийн мэдээ мэдээллийг шилэн дансны сайтад байршуулан ажиллаж байна.

Шилэн дансны мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй байршуулсныг хяналт тавих, дүн шинжилгээ хийх ажлыг Хяналт шалгалт дотоод аудитын тасгаас байнга хэрэгжүүлэн ажиллаж байна.

4. Үндсэн хөрөнгийн тооллогоор ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн хөрөнгүүдийн жагсаалтыг тайлант он дуустал хугацаагаар тооцох, хөрөнгийн чанар байдалд үнэлгээ дүгнэлт гаргах, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж НДЕГ, ННДГ, ТӨБЗГ-т тайлант хугацаанд актлах болон дахин үнэлгээ хийгдэх хөрөнгийн жагсаалтыг гаргаж байна.

2022 онд ТӨБЗГ-аас жилд 1 удаа актлах хөрөнгийн жагсаалт нэгтгэн авсан тул хөрөнгийн чанар байдлыг үндэслэн он дуустал хөрөнгийн элэгдлийг тооцон актлах болон дахин үнэлгээний саналаа хүргүүлээгүйгээс дээрх 3 нэрийн, 8 ширхэг 6350,0 төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хасуулаагүй тул 2023 оны жилийн эцсийн байдлаар эд хөрөнгийн тооллого хийж үр дүнг нэгтгэн хөрөнгийг актлах саналыг ТӨБЗГазарт хүргүүлэн ажиллаж байна.

Цаашид үндсэн хөрөнгийг элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртөгөө нөхсөн, нөхөөгүй ч засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон бодит үнэ цэнийг тогтоох, дахин үнэлгээ хийлгэх зэрэг саналыг бэлтгэж холбогдох байгууллагуудад хандаж шийдвэрлүүлэх болно.

5. Авлага бууруулах ажлын хүрээнд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд: Орлого шимтгэлийн байцаагч тус бүр аж ахуйн нэгж байгууллагуудаа авлага барагдуулах чиглэлээр өр авлага үүссэн хугацаа, авлагын насжилт, 10-аас дээш сая төгрөгийн буюу их хэмжээний өртэй, ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, албан шаардлага хүргүүлэн, авлага барагдуулах график байгуулж ажиллаж байна.



Энэхүү ажлын үр дүнд 3939,7 сая төгрөгийн өртэй 23 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж, хуваарь гарган уулзалт тэмдэглэл хөтөлж баталгаажуулснаар 1881,8 сая төгрөгийн өр авлага барагдсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн 16837,1 сая төгрөгийн өртэй 434 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээр, 144 ажил олгогчийн 5210,5 сая төгрөг, гэрээ байгуулсан боловч гэрээний хугацааг зөрчсөн, албан шаардлагын дагуу өр авлагаа барагдуулаагүй байгууллагын харилцах дансны гүйлгээг зогсоосноор 44 байгууллагын 461,3 сая төгрөгийн авлагыг барагдууллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй шүүхэд нэхэмжилсэн аж ахуйн нэгжийн өрийг барагдуулах ажлын хүрээнд 2023 оны хагас жилийн байдлаар харьяа дүүргийн шүүхэд нийгмийн даатгалын хуримтлагдсан авлага барагдуулах талаар холбогдох баримт материалыг хавсарган, 73,2 сая төгрөгний өртэй 2 ажил олгогчийг шүүхэд нэхэмжилж, хаяг байршил нь тодорхойгүй гэсэн үндэслэлээр шүүхээс буцаагдсан 7 ажил олгогчийг Эрэн сурвалжлуулахаар харьяа дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд холбогдох материалыг бүрдүүлэн өгсөн.

Өр барагдуулах талаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийн дагуу Чингэлтэй дүүргийн Прокурорыг зохигчоор оролцуулж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн талаар хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ШШГА-тай, мөн Нийслэлийн нийгмийн даатгалын газартай хамтран ажиллаж байна.

Мэдээллийн технологийн нэвтрүүлэлт, цахимжуулалтын ажлын хүрээнд

Байгууллагын дотоод сүлжээний тасалдалгүй ажиллагаа, ашиглалтыг хангаж, нийт 26 байцаагчийн компьютерын үйлдлийн системийг шинээр суулгасан. Нийгмийн даатгалын үйлчилгээнд өдөр тутам ашиглагддаг программ хангамжийг компьютерт суулгаж, нэмэлт шинэчлэлтүүдийг суулгасан. Үүнд:

Тэтгэврийн программ – 4 удаа

Тэтгэмжийн программ – 6 удаа

Харилцахын программ – 3 удаа

Үйл ажиллагааны программ – 4 удаа

1 байцаагчийн компьютерийн эх хавтан гэмтэж сольсон, 1 байцаагчийн компьютерийн хард шатаж сольсон, 4 лазер принтерийн цаас татагч сольж хэвийн ажиллагааг өдөр тутамд хангаж албан хаагч нарт мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан.

МТТ-өөс гаргасан журмын дагуу 22 байцаагчийн өдөр тутамд ашигладаг программуудын нууцлалыг АДМИН программын удирдлагаар хэрэгчлэгчдийн нууц үгийг солиулж, программын аюулгүй ажиллагааны талаархи зөвлөгөө мэдээлэл өгч, улирал тутам нууц үгийг өөрчлүүлж гарын үсгээр баталгаажуулсан.

Ухаалаг ажлын байр төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд **“Үнэлгээний систем”**-ыг хэвийн ажиллагааг тухай бүр хангаж, нэмэлт сайжруулалтуудыг хийж ажиллаж байна.

Албан хэрэгцээний программ хангамжын хэрэглэгчдийн эрх, ашиглах цэс зэрэг судалгааг гарган удирдлагад танилцуулан шаардлагатай мэдээллийг гарган өгсөн.

МТТөвтэй холбогдож байгууллагын албаны мэйл хаягийг 6 байцаагч ажилтанд шинээр авч, 20 байцаагч ажилтаны нууц үгийг солиулсан. Дотоод хяналтын программыг 1 байцаагчид, дотоод чат буюу инбитын эрхийг 12-г шинээр нээлгэж, ашигладаггүй 12 инбит хаягыг устган зохицуулалтыг хийж ажилласан.

“Нийгмийн халамж, хөдөлмөр, нийгмийн даатгалын хэлтсүүдэд вэбд суурилсан дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем” хөгжүүлэх ажлын хүрээнд тус хэлтэс нь өөрийн домэйн, хост эрхтэй (пинукс) болох зорилгоор Үндэсний дата төвд хүсэлт явуулж, хамтран ажиллах гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Даатгуулагчдын гар утсандаа суулгасан аппликейшнд нэвтрэх эрхийг баталгаажуулжуулах үйлчилгээг 302 удаа, 89 нууц үгийг мсж-ээр илгээж, 58 удаа бүртгэлийн мэдээллийг засварлаж ажиллаж байна.



ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

2023 оны 4 улирлын байдлаар Нийгмийн даатгалын салбарт ашиглагдаж буй ABLE программ болон хүний нөөцийн шинэ программд хэлтсийн нийт 55 албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж ажиллаж байна.

Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн, шинээр ажилд томилогдсон болон төрийн өөр байгууллагад шилжсэн, ажлын зайлшгүй шаардлагаар өөрийн хүсэлтээр нэгж дотор шилжүүлэн ажиллуулсан нийт 109 албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн мэдээллийн санд бүртгэж өөрчлөлт оруулж ажилласан.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн цахим программаар www.hr.csc.gov.mn хүний нөөцийн тайланг хуулийн хугацаанд гаргаж, хэлтсийн 55 албан хаагчийн мэдээллийг үнэн зөв шивж, тухайн бүр нь оруулж, шинэчлэсэн. Төрийн албаны зөвлөлийн www.hr.csc.gov.mn цахим программд ажилтан, албан хаагч нарын мэдээллийг оруулснаар хүний нөөцийн тайлан гаргахад хялбар болсон. Тухайн албан хаагчийн мэдээллийг Төрийн албаны зөвлөл шууд хянах боломжтой болсон.

Мөн Нийгмийн даатгалын Ерөнхий газраас хэрэгжүүлж буй “Green ERP” хүний нөөцийн мэдээллийн программд хэлтсийн 7 албан хаагчдын ерөнхий мэдээлэл болон бусад мэдээллийг программд оруулж ажиллаж байна.

Авлигын эсрэг хуулийн 18.4.10-т заасны дагуу хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргийн хүрээнд хэлтсийн нийт албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулан авч, байгууллага болон хувь хүний нууцыг бусдад задруулахгүй байх үүргийг хэрэгжүүлэх талаар албан хаагчдад тогтмол зөвлөмж анхааруулга өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн <https://meduuleg.iaac.mn/> сайтад хэлтсийн нийт 29 төрийн захиргааны албан хаагч нарын 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд бүртгэн оруулж тухайн албан хаагчийн мэдээллийг нийтэд ил нээлттэй болгосон.

Нийгмийн даатгалын ерөнхийн газрын даргын 2018 оны А/22 тушаалаар батлагдсан бүтэц, орон тоог мөрдөж, орон тооны хэтрэлтгүй ажиллаж,

- Удирдах албан тушаалтан 1,
- Гүйцэтгэх албан тушаалтан 38,
- Туслах албан тушаалтан 2,
- Гэрээт 6, орон тоонд багтаан ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхийн газрын даргын 2018 оны А/22 тушаалаар баталсан бүтэц орон тооны дагуу ажиллаж байна. Мөн нийслэлийн нийгмийн даатгалын газарт хүний нөөцийн тайланг үнэн зөв хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

4.1 Хүний нөөцийн төлөвлөлт, зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2018 оны А/22 тушаалаар батлагдсан бүтэц, орон тоог мөрдөж, орон тооны хэтрэлтгүй ажиллаж, хүний нөөцийн өөрчлөлт, хөдөлгөөний тайланг тогтоосон хугацаанд ННДГ-т хүргүүлж, ажилласан бөгөөд нийт албан хаагч нартай холбоотой, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой тушаалуудыг тус тус боловсруулж төсвийн шууд захирагчаар хянуулсан. Мөн үйлчилгээний 14 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг байгуулж ажилласан болно.

Дээд шатны байгууллага болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын гаргасан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, мөрдлөг болгон ажиллаж, биелэлтийг нь хангаж, хугацаанд нь тайлагнасан. Биелэлтэд тус хэлтсийн Хяналт шалгалт дотоод аудитын тасгаас хяналт-шинжилгээ үнэлгээ хийж зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан гэж дүгнүүлсэн. Ингэснээр дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлт бүрэн хангагдсан.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай шийдвэрлэж ажилласан. Аж ахуйн нэгж байгууллага, эрх бүхий байгууллагаас ABLE программ болон EDOC программаар нийт 6 өргөдөл, гомдол ирснээс холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хуулийн хугацаанд шийдвэрлэж, холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлж ажилласан. Иймд иргэд даатгуулагч болон хуулийн этгээдээс хугацаа хэтрүүлсэн албан бичиг болон өргөдөл гомдолгүй ажиллаж байна.

Нийгмийн даатгалын салбарт ашиглагдаж буй ABLE программ болон нийгмийн даатгалын ерөнхий газрын хүний нөөцийн программд хэлтсийн нийт 47 албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн, өөрчлөн оруулж ажилласан. Мөн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн, шинээр ажилд томилогдсон, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, болон төрийн өөр байгууллага, ажлын зайлшгүй шаардлагаар өөрийн хүсэлтээр нэгж дотор шилжүүлэн ажиллуулсан нийт 35 албан хаагчийн мэдээллийг мэдээллийн санд бүртгэж өөрчлөлт оруулж ажилласан. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлийн HRCSC программаар хүний нөөцийн тайланг хуулийн хугацаанд хэлтсийн 47 албан хаагчийн мэдээллийг үнэн зөв шивж, тухайн бүр нь оруулж, шинэчилсэн болно.

Төрийн албаны зөвлөлийн HRCSC программд ажилтан, албан хаагч нарын мэдээллийг оруулснаар хүний нөөцийн тайлан гаргахад хялбар болсон. Тухайн албан хаагчийн мэдээллийг Төрийн албаны зөвлөл шууд хянах боломжтой болсон. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрэгжүүлж буй “Green ERP” хүний нөөцийн мэдээллийн программд хэлтсийн 47 албан хаагчдын ерөнхий мэдээллийг программд тухай бүр шинэчлэн оруулж, ажиллаж байна.

Тус хэлтсийн төрийн үйлчилгээний 8 албан хаагчид ур чадварын нэмэгдэлийг 15-25%-иар бодож тухай бүр олгож байна.

CALL CENTER үйлчилгээнд 1 төлөөлөгч байцаагчийг шинээр томилж, нийгмийн даатгалын хууль тогтоомж ажил үйлчилгээний талаар иргэд даатгуулагчдад шууд утсаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.



Дээд газраас ирүүлсэн болон төрийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн нийт 41 гаруй судалгаа, мэдээллийг хуулийн хугацаанд нь гаргаж, төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж хүргүүлсэн.

4.2 Сургалт сурталчилгааны ажлын хүрээнд

Хэлтсийн сургалт сурталчилгааны жилийн ажлын төлөвлөгөөг 2023 оны 01 сарын 19-ний өдөр батлан гаргаж, төлөвлөгөөний хүрээнд 2023 онд албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтууд, иргэд даатгуулагчид, ажил олгогч, аж ахуй нэгж, байгууллагуудыг хамруулсан цогц сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт чиглэсэн сургалтууд




Сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны 2 сард жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд даатгуулагчдад зориулан нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор Нийслэлийн болон Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес инкубатор төв дээр нийт 130 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан 1 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2022 оныг “Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил” болгон зарласантай холбогдуулан нэрэмжит жилийн уриа бүхий мэдээллийн самбарыг тус хэлтсийн Угтах үйлчилгээний хэсэг болон Хайлааст дах тасгийн байранд байршуулж, иргэд даатгуулагчдад сурталчлан ажиллаж байна.



Тус хэлтэс нь 2023 оны 2 сарын 15-17-ний өдрийн хугацаанд дүүргийн хороодтой хамтран “ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ” явуулын үйлчилгээг зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 490 гаруй иргэд даатгуулагчдад тэтгэвэр тогтоолгох талаарх сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуультай хамтран “Даатгалтай ирээдүй” сургалт өдөрлөгийг зохион байгуулж, тус сургуулийн 12а, 12б ангийн нийт 54 сурагчид нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Тус хэлтэс нь нийгмийн даатгалын ажил үйлчилгээг сурталчлан таниулах, иргэд даатгуулагчдад мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт төв зам дагуух сурталчилгааны самбарт нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, Ухаалаг ажлын байрны танилцуулга, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх талаар мэдээлэл байршуулж иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэж ажилласан.



Нийслэлийн ерөнхий боловсролын 138 дугаар сургууль, 50 дугаар сургууль 56 сурагч, 220 дугаар цэцэрлэг, 21 дүгээр хорооны иргэдэд “Даатгалтай ирээдүй”, “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж”, “Эрүүл мэндийн даатгал” сургалт өдөрлөгийг 2023 оны 3 сарын 10-ний өдөр зохион байгуулж, тус сургуулийн 10а, 10г ангийн нийт 67 сурагчид, глобал удирдагч дээд сургааль 67 оюутан сурагч мөн албан хаагчид 38 нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Нийслэлийн ерөнхий боловсролын 17 дугаар сургуультай хамтран “Даатгалтай ирээдүй” сургалт өдөрлөгийг зохион байгуулж, тус сургуулийн 12а, 12б ангийн нийт 54 сурагчид нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.



Сургалтын төлөвлөгөөний дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд даатгуулагчдад зориулан нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор Нийслэлийн болон Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес инкубатор төв дээр 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр нийт 130 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан 1 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан.

Нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг ил тод байлгах, иргэдэд мэдлэг олгох хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор тус хэлтэст шимтгэл төлөгч Үлэмж просерс ХХК удирдлага, нягтлан бодогч ажилтнуудад сургалт зохион байгууллаа. Сургалтаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, цахим үйлчилгээ сэдвийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Тус хэлтэст шимтгэл төлөгч Сүхбаатар дүүргийн Прокурорын газарт Нийгмийн даатгалын тухай ойлголт өгөх, цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор сургалт зохион байгууллаа. Сургалтаар Хяналт шалгалтын байцаагч Г.Гэрэлээ "Нийгмийн даатгалын тухай ойлголт", магадлагч эмч Ж.Өнөгэрэл Тэтгэвэр, тэтгэмж, цахим үйлчилгээ" сэдвийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Тус хэлтэс нь зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжигч, даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай ойлголт ач холбогдлыг таниулах, цахим үйлчилгээг түргэн шуурхай авах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийн дэвжих төв”-тэй хамтран 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр мэдлэг мэдээлэл олгох сургалтыг хамтран зохион байгуулж, нийт 53 жижиг дунд

үйлдвэрлэл эрхлэгч, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээ тэтгэвэр, тэтгэмжийн анхан шатны ойлголтуудыг өгч, нийгмийн даатгалын аппликейшнийг 14 даатгуулагч иргэнд баталгаажуулж өгч ажиллалаа. Тус хэлтсийн 3 албан хаагч оролцож, нийт 55 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, нийгмийн даатгалын аппликейшнийг сурталчлан таниулж, цахим бүртгэл мэдээлэл, регистрийн дугаар болон мэдээлэл зөрүүтэйг засах үйлчилгээ цахимаар хийж баталгаажуулалтыг сурталчлан таниулж, иргэд даатгуулагчдад 35ш нийгмийн даатгалын гарын авлага, брошур тарааж ажилласан.




№	Ирэгч	Төлөө	Хүний нэр	Хүний нэр	Хүний нэр
1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28
29	29	29	29	29	29
30	30	30	30	30	30
31	31	31	31	31	31
32	32	32	32	32	32
33	33	33	33	33	33
34	34	34	34	34	34
35	35	35	35	35	35

№	Ирэгч	Төлөө	Хүний нэр	Хүний нэр	Хүний нэр
1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28
29	29	29	29	29	29
30	30	30	30	30	30
31	31	31	31	31	31
32	32	32	32	32	32
33	33	33	33	33	33
34	34	34	34	34	34
35	35	35	35	35	35

№	Ирэгч	Төлөө	Хүний нэр	Хүний нэр	Хүний нэр
1	1	1	1	1	1
2	2	2	2	2	2
3	3	3	3	3	3
4	4	4	4	4	4
5	5	5	5	5	5
6	6	6	6	6	6
7	7	7	7	7	7
8	8	8	8	8	8
9	9	9	9	9	9
10	10	10	10	10	10
11	11	11	11	11	11
12	12	12	12	12	12
13	13	13	13	13	13
14	14	14	14	14	14
15	15	15	15	15	15
16	16	16	16	16	16
17	17	17	17	17	17
18	18	18	18	18	18
19	19	19	19	19	19
20	20	20	20	20	20
21	21	21	21	21	21
22	22	22	22	22	22
23	23	23	23	23	23
24	24	24	24	24	24
25	25	25	25	25	25
26	26	26	26	26	26
27	27	27	27	27	27
28	28	28	28	28	28
29	29	29	29	29	29
30	30	30	30	30	30
31	31	31	31	31	31
32	32	32	32	32	32
33	33	33	33	33	33
34	34	34	34	34	34
35	35	35	35	35	35



Дүүргийн иргэний бүртгэлийн хэлтсийн хороод хариуцсан мэргэжилтэн болон хэлтсийн бүртгэгч ажилтан, нягтлан бодогч, албан хаагчдыг хамруулан танхимын болон цахим сургалт зохион байгуулж, нийт 67 гаруй нягтлан бодогч, албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Улаанбаатар смарт карт ХХК-ын албан хаагчдыг хамруулан Нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулга, тэтгэвэр тэтгэмжийн тухай ойлголт сургалт зохион байгуулж, нийт 32 гаруй нягтлан бодогч, албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Цээб ХХК, Очир Ундраа ХХК, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, цагдаагийн ерөнхий газрын харьяа мэдээлэл шуурхай удирдлагын төвийн албан хаагчдыг хамруулан Нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулга, тэтгэвэр тэтгэмжийн тухай ойлголт сургалт зохион

байгуулж, нийт 190 гаруй албан хаагч, нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Тус хэлтэс нь 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 23-ний өдрүүдэд MGBS ХХК-тай хамтран “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгуулж, 2 өдрийн 4 ээлжээр нийт 160 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтад хамрагдууллаа. Тус сургалтын хүрээнд ХАБЭА-н асуудал хариуцсан ажилчдын ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандартын мэдлэгийг дээшлүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, ажлын байран дахь хөдөлмөрийн сөрөг хүчин зүйлсийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо ажил олгогчийн ХАБЭА-н манлайллыг нэмэгдүүлэх, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал, эрсдэлийн түвшинг бууруулах ойлголтыг өгөх сургалтыг зохион байгууллаа. Мөн ХАБЭА-н асуудал хариуцсан ажилчдын ХАБЭА-н талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх зорилгоор асуулт хариултын тэмцээн зохион байгуулж мэргэжлийн ном гарын авлагаар шагнаж, сургалтын төвийн үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг авлаа. Сургалтад хамрагдсан байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулан гарын авлага брошур тарааж, CERTIFICATE гардуулан, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.





“ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН (сургууль, цэцэрлэг) НЯГТЛАН БОДОГЧ НАРТ ЗОРИУЛСАН” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА


Тус хэлтэс нь 2023 оны 10 дугаар сарын 30-ний өдөр төсөвт байгууллагын нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, журам заавар, цахим үйлчилгээний талаар, шимтгэл төлөлтийн тайланд гарч байгаа зөрчлүүдийг арилгах, хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнахад мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг хэлэлцэж, цаашид зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх талаар сургалт уулзалтыг зохион байгуулж харилцан санал солилцлоо.

Сургалтаар хуулийн хэрэгжилт болон аж ахуйн нэгж байгууллагуудын нийтлэг гаргадаг алдаа дутагдлыг арилгуулах цаашид анхаарах асуулаад орлого шимтгэлийн тасгийн дараг М.Отгонцэцэг, байцаагч Б.Ариунтуяа, байцаагч Г.Энэбиш нар сургалтыг удирдан явуулсан.





Мэдээлэл дүн шинжилгээ шуурхай удирдлагын албад 2023 оны 10 дугаар сарын 08-ний өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулга, тэтгэвэр тэтгэмжийн тухай ойлголт сургалт зохион байгуулж алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн 55 байгууллагын алба хаагчдыг хамрагдаж оролцлоо. Тус алба хаагчид сургалтад хамрагдсанаар цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай тодорхой төрлийн ойлголт, шинэ хуулийн өөрчлөлт, цахим үйлчилгээний зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.



Явуулын үйлчилгээ, Нээлттэй хаалганы өдөрлөг

Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор тус хэлтэс нь 2023 оны 3 дугаар сарын 15-ний өдөр дүүргийн хороодтой хамтран “ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ” явуулын үйлчилгээг зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг

сурталчлан таниулж; 2022, 2023 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 490 гаруй иргэд даатгуулагчдад тэтгэвэр тогтоолгох талаарх сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.



Тус хэлтэс нь 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр “ХАМТДАА ОРОЛЦЪЁ, ХАМТДАА ХӨГЖЬЕ-2” уулзалт хэлэлцүүлэгт оролцлоо. Хэлэлцүүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалахад чиглэсэн төрөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, хэрэгжилт, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж бусад үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал хүсэлтийг сонсох, зөвлөн туслах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, дүүргийн 1-24 дүгээр хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийт 300 гаруй даатгуулагч иргэдэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, даатгуулагч нарт нийгмийн даатгалаас үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээ” сэдвээр сургалт, мэдээлэл өгч ажиллалаа.

Чингэлтэй дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн хөгжлийн төвийн зохион байгуулсан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжигч нийт 43 даатгуулагчдад “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэтгэвэр, тэтгэмж, цахим үйлчилгээний мэдээлэл ерөнхий ойлголт өгөх” сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр танхимаар зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан үйлдвэрлэгчдын СДД-ын хамралтын хийж гэрээг онлайнаар байгуулж ажилласан.



Нийслэлийн засаг даргын тамгын газраас зохион байгуулж буй өдөрлөгт тус хэлтэс нь 2023 оны 04 дүгээр сарын 26,27-ны өдрүүдэд 10:00-18:00 цагийн хооронд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж буй "Хүний хөгжил-Нийгмийн хөгжил" нийгмийн салбарын нэгдсэн өдөрлөгт оролцож 150 гаруй иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцон нийгмийн даатгалын гар утасны аппликейшний мэдээлэл өгч баталгаажуулж ажилласан.



Монголын хуульчдын холбооноос зохион байгуулж байгаа "ХУУЛЬЧИЙН ПРОБОНО" өдөрлөг Сүхбаатарын талбайд 2023 оны 05 дугаар сарын 01 өдөр 10:00-18:00 цаг хүртэл зохион байгуулагдана. Тус хэлтэс нь Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч нийт 100 гаруй иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцон нийгмийн даатгалын гар утасны аппликейшн баталгаажуулж ажилласан.



Тус хэлтэс нь 2023 оны 05 дугаар сарын 17-ний өдөр 10:00-18:00 цагийн хооронд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдаж буй "Хөдөлмөр, халамжийн" салбарын нэгдсэн өдөрлөгт оролцож зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна



Ажил олгогч захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудын сургалт, зөвлөгөөнийг 2023 оны 5 сарын 19-ны өдөр цахим болон танхимаар хослуулан зохион байгууллаа.

Энэхүү сургалтад их хэмжээний шимтгэлийн өр үүсгэсэн болон шинээр байгуулагдсан аж ахуй нэгж байгууллагуудаас сонгон, танхимаар нийт 400 байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудыг хамруулсан.

Тус хэлтэс нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулах, цахим үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээллийг өгөх зорилгоор ажил олгогчийн зөвлөгөөнийг зохион байгууллаа.



Зөвлөгөөнд урилгаар:

“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, хэрэгжилтэд анхаарах асуудлууд сэдвээр НДЕГ, БХСГ-ын НД-ын бодлого хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн, улсын байцаагч С.Лхагвадорж “Нийгмийн даатгалын хяналт шалгалтын тухай” сэдвээр НДЕГ-ын Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Б.Батсуурь “Тоон гарын үсгийн хэрэглээ заавар зөвлөмж” сэдвээр “Нью компас”- ХХК-ийн захирал Н.Эрдэнэбулган нар сургагч багшаар оролцож 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр ажил олгогчдын зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцсон байгууллагуудын нягтангуудыг зөвлөгөөний үеэр хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангаж, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, бусдыгаа манлайлсан шилдэг ажил олгогч, шилдэг нягтлан бодогчдыг шалгаруулан шагнаж урамшууллаа.



Сургалтад танхимаар хамрагдсан нийт байгууллагын захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудад тайлан илгээхэд анхаарах асуудал, цахим тэтгэмжийн үйлчилгээ, тэтгэмжийн хүсэлтийн цахимаар илгээх заавар, тоон гарын үсгийн танилцуулга зэрэг 4 төрлийн 5484ш гарын авлага брошур тарааж ажилласан.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, цахим үйлчилгээний талаар иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэх, ажил үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор уг сургалт зөвлөгөөний үеэр ТВ8 телевизтэй хамтран мэдээ бэлтгэж, ажил олгогч нарт мэдээлэл хүргэж ажилласан.



Тус хэлтэс нь уг сургалт, зөвлөгөөний үеэр Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, даатгуулагчийнхаа нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа 10 байгууллагыг “Шилдэг ажил олгогч”-оор шалгаруулж, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан.



Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Чингэлтэй фестиваль” “Шинэ сэргэлт Чингэлтэй” уриан дор Чингэлтэй фестиваль нь соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, үндэсний соёл урлаг, өвийг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилготой уг өдөрлөг тус хэлстийн албан хаагчид оролцлоо.



Төрийн байгууллагад “Процессын дахин инженерчлэл” хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүний сургалтанд хэлтсийн удирдлага болон 3 албан хаагч 2023 оны 06 сарын 19-өдөр “Процессын дахин инженерчлэл” уулзалт, хэлэлцүүлэг оролцож санал хүсэлтээ хүргүүлж ажилласан. Тус уулзалт, хэлэлцүүлэгт төрийн албаны бүтээмж, чадамжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг үзүүлж буй албан хаагчид болон үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан.

Сургалтын төлөвлөгөөний дагуу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд даатгуулагчдад зориулан нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор Нийслэлийн болон Чингэлтэй дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих Бизнес инкубатор төв дээр нийт 130 гаруй бизнес эрхлэгчдийг хамруулан 1 удаагийн сургалт зохион байгуулан ажилласан.

2023 оны “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийгмийн даатгалын хууль тогтоомж шинэчилсэн найруулга, тэтгэврийн зөвлөгөө мэдээллийг нийт 43 иргэд даатгуулагчдад хүргэж 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 03-ний өдрийг хүртэлх хугацаанд Тусгаар тогтнолын талбайд "Иргэдэд үйлчлэх нээлттэй өдөрлөг"-т оролцож ажилласан. Тус өдөрлөгт жижиг дунд үйлдвэрлэгч ногоочин А.Ариунболдоос хэлтсийн албан хаагчид нийт 8 төрлийн нөөшилсөн ногоо худалдан авч үйлдвэрлэгчдийг дэмжин ажилласан. Нийт 8 төрлийн 46 ширхэг шилтэй бүтээгдэхүүнийг хэлтсийн байранд авчран худалдан авалт хийсэн. Мөн ноос ноолууран бүтээгдэхүүн худалдаалж байсан даатгуулагч иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.





Тус хэлтэс нь “ЗӨВЛӨЕ ТУСАЛЪЯ” ажил үйлчилгээг 2023 оны 11 дүгээр сарын 04-ны өдөр Чингэлтэй дүүргийн хороодтой хамтран зохин байгуулж, дүүргийн 1-12,21-22-р хорооны иргэд даатгулагч, 12 дугаар хорооны “Чингэлтэйд үйлдвэрлэв 2 төв”-ийн хувиараа биенес эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж, Нийгмийн даатгалын тухай шинэчилсэн хууль тогтоомжийг суртатчлан, 2023-2024 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсч байгаа иргэдэд тэтгэвэр тогтоолгох талаар мэдээлэл зөвлөгөө өгч, нийгмийн даатгалын аппликейшныг иргэдийн гар утсанд суурилуулан баталгаажуулан ажиллалаа. Тус дүүргийн 13-20,23,24 дүгээр хорооны иргэд даатгуулгачдад 11 дүгээр сарын 11-ны өдөр 15-19 дүгээр хорооны иргэний танхимд зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан.

Чингэлтэй дүүргийн 1-24 дүгээр хорооны 2023, 2024 онд (1963,1964 оны эрэгтэй, 1968,1969 оны эмэгтэй) өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй иргэдийн материалыг урьдчилан шалгаж, зөвлөгөө өгөч нийт 400 гаруй иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Хувиараа бизнес эрхлэгч иргэд нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж сайн дурын даатгалын гэрээг хийж, нийгмийн даатгалын аппликейшныг иргэдийн гар утсанд суулган баталгаажуулан ажилласан.





“ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ” аяныг 2023 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Чингэлтэй дүүргийн хороодтой хамтран зохион байгуулж ажиллалаа. Дүүргийн 13,15,17 дугаар хороодын иргэдэд 15 дугаар хорооны иргэний танхимд, 16,17,23 дугаар хорооны иргэд даатгуулагчдад 17 дугаар хорооны иргэний танхимд, 19,20,24-р хорооны иргэд даатгуулагчдыг 19 дугаар хорооны иргэний танхимд хүлээн авч Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомж түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг сурталчлан таниулах, 2023-2024 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход эрх нь үүсч буй иргэдийн тэтгэврийн материалыг шалган нийт 240 иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Хувиараа хөдөлмөр эрхлэгч даатгуулагч 42 иргэн сайн дурын даатгалын гэрээ бусад даатгалын үйлчилгээг авлаа.





2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газраас зохион байгуулж буй “Хөдөлмөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” хуулийн танилцуулга сэдвээр сургалт зохион байгуулж ажиллалаа. Дүүргийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарласантай холбоотойгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг дунд үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг талаар мэдээллийг нийт 60 датгуулагч иргэнд хүргэж ажиллалаа.





2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Нийслэлийн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран жижиг дунд бизнес худалдаа эрхлэгч иргэдэд “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл” хуулийн танилцуулга, сайн дурын даатгал сэдвээр сургалт зохион байгуулж ажиллалаа. Дүүргийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарласантай холбоотойгоор хувиараа хөдөлмөр эрхлэгч болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд даатгуулагчдад, нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг талаар мэдээллийг нийт 86 датгуулагч иргэнд хүргэж ажиллалаа.




2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр “БҮТЭЭЛЧ ДҮҮРЭГ-ХАМТЫН АЖИЛЛАГАА” АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН ЗӨВЛӨГӨӨН 2023” -д оролцлоо.

Зөвлөгөөнөөр дараах асуудлыг хөндөж, илтгэлүүд өрнөсөн юм. Үүнд: “Чингэлтэй дүүргийн хэмжээнд аж ахуй нэгж байгууллага”, ажил олгогчид чиглэсэн үйл ажиллагаа, бодлого, хамтын ажиллагаа түншлэл”, “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих эдийн засгийн бодлого чиглэл”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /ажлын байрны дадлагажуулагчийн тухай/, “Татварын шинэчлэлт, анхаарах асуудлууд”, “Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга”, “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулалт”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд ажил олгогчийн үүрэг оролцоо” зэрэг сэдвээр илтгэлүүд хэлэлцлээ. Зөвлөгөөнд 220 аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтнууд оролцож, өөрсдөд тулгамдаж буй асуудлууд болон цаашид хийж хэрэгжүүлэх ажлынхаа талаар санал солилцлоо.



2023 оныг Чингэлтэй дүүрэг “Үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласан бөгөөд энэ хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 25 -ны өдөр “Мишээл Экспо” олон улсын үзэсгэлэн худалдааны төвд “Чингэлтэйд үйлдвэрлэв-2023” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж тус хэлтэс нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.






Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах талаар

Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор хэлтсийн албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.


2023 оны IV улирлын байдлаар нийт 24 удаа шууд Live хийж, 16560 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна. Иргэд даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын ажил үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг цахимаар түргэн шуурхай хүргэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор хэлтсийн албан ёсны Facebook цахим хаягаар дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол мэдээ мэдээлэл хүргэж, батлагдсан хуваарийн дагуу сар бүр шууд Live хийж, цахимаар зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.



Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээг иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор www.npost.mn, www.ikon.mn, www.ulaanbaatar.mn, www.arslan.mn зэрэг сайт дээр нийтлэл бэлтгэн оруулж, ярилцлага өгч зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.



Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээж авах, тогтоох, олгох ажлыг сурталчлан таниулах зорилгоор тус хэлтэс нь тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх QR код бүхий 2 төрлийн заавар хийж, гарын авлага брошюр бэлтгэн, иргэд даатгуулагчид, ажил олгогч нягтлан бодогч нарт тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.



Ажилтан, албан хаагчдад чиглэсэн сургалтууд

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчид- бид авлигын эсрэг хамтдаа нэгдэж “Нийгмийн даатгал-Авлигагүй бүс” цахим аянд нэгдэж , засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг үе шаттай зохион байгуулж байгаа постыг өөрийн цахим хуудсаар дамжуулж нийт албан хаагчид 39 удаа дамжуулан нийтэлсэн.



“Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр анхаарах асуудлууд, Тоон гарын үсэг ашиглан албан бичиг боловсруулах нь” сэдвээр тус хэлтсийн нийт албан хаагчиддад сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр анхаарах асуудлууд, албан хэрэг хөтлөлтийн стандарт журмыг мөрдөн ажиллах сургалтыг үйлчилгээний тасаг, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нар зохион байгуулж сургалтыг ЧДЗДТГ-аас ирж сургалтыг удирдан зохин байгуулж хийлээ.

Ажлын байран дах стрессээс хэрхэн өөрийгөө чөлөөлөх, стрессээ удирдах суралцах, ажлын байран дах эерэг уур амьсгалыг бүрдүүлсэн байх зорилгоор хэлтсийн сургалтыг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 27-ний өдөр гэр бүл судлаач сэтгэл зүйч М.Баясгалан багшийг урьж сургалтыг зохион байгууллаа.



Тус хэлтэс нь нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудыг ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулж, сургалтын файл хичээлүүдийг албан хаагчдад тараан өгч, бие даан судлуулсан.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт, дээд байгууллагаас ирсэн журам чиглэлийг нийт байцаагч албан хаагчдад таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор тус хэлтсийн Үйлчилгээний тасгийн дарга З.Мөнхнаран, хэлтсийн нийт байцаагч албан хаагчдад чадавхжуулах сургалт зохион байгуулж, чиглэл зөвлөмж өгч ажилласан.

НДЕГ-аас зохион байгуулж буй Шинэ ажилтны чадавхжуулах сургалтад нийт 4 албан хаагч хамрагдаж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлголцоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хяналт шалгалтын байцаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2023.03.31-ний өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулагдаж тус сургалтад хяналт шалгалтын 2 албан хаагчид цахимаар, 2 байцаагч танхимаар сурч (<https://surgalt.ndaatgal.mn/>) тус тус оролцлоо.

Хэлтсийн архивын албан хэрэг хөтлөлт хөтлөх хэргийн нэрийн жагсаалт түүний стандарт, хэрэглээ сэдвээр архивын ажилтан С.Энхцарал сургагч багшаар ажиллаж мэдээлэл зөвлөгөөг өглөө.

Архив бичиг хэрэг хөтлөлт, анхаарах асуудал сэдвийн хүрээнд Архивын Ерөнхий газраас сургалт зохион байгууллаа. Сургалтаар Архивын баримт хадгалалт хамгаалалт болон стандартын талаар мэдээлэл өгөв. Сургалтын үр дүн: Архивын баримт хүлээлгэн өгөхөд анхаарах асуудал, албан хэрэг хөтлөлтийн дүрэм журмын талаар ойлголт авсан.



2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Чингэлтэй дүүргийн засаг даргын тамын газраас зохион байгуулж буй “Хууль эрх зүй” сургалтанд тэтгэвэрийн байцаагч Б.Баярмаа, архивын ажилтан С.Энхцацрал нар хамрагдав.



Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, авлигын эсрэг мэдлэг хандлагыг төлөвшүүлж авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгууллаа. Сургалтаар "Авлигын гэмт хэрэг, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдвийн хүрээнд хэлтсийн албан хаагчдад мэдээлэл өглөө. 2023 оны 3, 4 сард НДЕГ-аас зохион байгуулсан тэтгэвэр, тэтгэмж тогтооход анхаарах асуудал, цахим тэтгэмжийн талаарх сургалтад нийт 31 албан хаагч хамрагдаж, дотооддоо сургалт зохион байгуулж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлт, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг нийт албан хаагчдад хүргэж, өдөр тутмын ажил үйлчилгээндээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

2023 оны 4 сарын 13-ны өдөр Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт, дээд байгууллагаас ирсэн журам чиглэлийг нийт байцаагч албан хаагчдад таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллах зорилгоор тус хэлтсийн Орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг, Үйлчилгээний тасгийн дарга З.Мөнхнаран, нар хэлтсийн нийт байцаагч албан хаагчдад чадавхжуулах сургалт зохион байгуулж, чиглэл зөвлөмж өгч ажилласан.



Сургалт дотооддоо зохион байгуулах, албан хаагчдадаа байнга архивын баримтын бүрдэл болон хадгаламжийн нэгжид тавигдах шаардлагатай холбоотой мэдээлэл, заавар, зөвлөмж өгөх зорилгоор 2023 оны 05 сарын 01-ны өдрийн 07:00 цагт хэлтсийн нийт албан хаагчдад архивын чиглэлээр сургалт зохион байгуулж, 08:00 цагт дууссан. Тайланг гарган удирдлагад танилцуулсан. Сургалтын зорилго: Архивын баримтаар бүрдэл үүсгэхэд ангилал төрлөөр ялгах, ХХНЖ-т батлагдсан хэргийн агуулгыг тодорхойлоход чиглэсэн.

Сургалтын агуулга: Албан хаагчдаасаа үүсэх баримтын ангилал төрөлд юу анхаарах, яаж хэрэг бүрдүүлэх, архивд баримтаа ямар шаардлага хангаж, эрх зүйн актуудыг үндэслэн бүрдүүлж хүлээлгэн өгөх талаар мэдээлэл солилцох, зарим буруу ойлголтыг залруулахад чиглэгдсэн.

Байгууллагын онцлогт нийцсэн жишээ болон НАГ-с гаргасан журам заавар, мэдээллийг эргэж харах боломж, хэрэглээнд зориулан слайдаар бэлтгэн файл хэлбэрээр дотоод сүлжээгээр өгч байнга ашиглах боломжтой. Сургалт зохион байгуулахад ажлын байранд кейс болгон баримтаар жишээ авч тайлбарласан ба НДЕГ-аас гаргасан "Салбарын

үлгэрчилсэн Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-г бүлэг бүрээр танилцуулж, асуулт хариултаар баталгаажуулан мэдээлэл солилцсон. Цаашлаад байнга заавар зөвлөгөө авах боломж нээлттэй байхаар ярилцаж, 2022 оны баримтаа архивд шилжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг цаг хугацаа алдахгүй асууж гүйцэтгэлийг хангахад анхааруулав. Албан хаагч бүр өөрсдөөсөө гарч буй цаасан баримтыг үнэлж, үнэ цэнтэй баримтыг архивд шилжүүлэхэд анхаарч ажиллах, албан тушаалын чиг үүрэгт багтсан байдаг учраас хэн нэгэндээ найдах, буруу мэдээлэл авах, холбогдох журам заавартай танилцаж эх сурвалжаа тогтооход яаж ажиллах талаар зохицуулалтыг мэддэг байх, хариуцлагатай хандах талаар сургалт явагдсан. Сургалтын үр дүнг 2022 оны баримтыг архивд шилжүүлэхэд үр дүнг үнэлж болох ба удирдлагад тайлангаар тухай бүрд нь танилцуулж байна.

Төрийн үйлчилгээний чанар, байгууллагын чадамж, бүтээмжийг дээшлүүлэх, иргэд болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, процесс суурьтай, оновчтой, үр ашигтай засаглалыг бэхжүүлэхэд оршиж буй тус ажилд төрийн байгууллагын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэлийг хийснээр дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Үүнд:

- Иргэдийн төрийн үйлчилгээг авахын тулд туулдаг шат дамжлагын тоог багасгана.
- Төрийн үйлчилгээг иргэдэд илүү шуурхай хүргэх боломжтой болно.
- Төрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой албан хаагчийн ажлын ачааллыг илүү тэнцвэртэй зохион байгуулах боломжтой болно.
- Төрийн үйлчилгээг хүргэх илүү олон сонголттой болж, иргэд хүссэн хэлбэрээр, хялбараар авах боломж бүрдэнэ.
- Захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг илүү оновчтой болгоно.
- Төрийн албаны бүтээмж, чадамж дээшилж, төрийн үйлчилгээг үзүүлж буй албан хаагч, үйлчилгээ авч буй иргэн аль алиных нь сэтгэл ханамж нэмэгдэх ач холбогдолтой.





Монгол Улсын их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор НДЕГ-аас 2023 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж тус хэлтсийн 34 албан хаагчдад хамрагдлаа.

“Нийгмийн даатгалын ерөнхий хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд сэдвээр сургалтад хамрагдсан.




Хэлтсийн сургалтын төлөвлөгөөний дагуу байцаагч ажилтан албан хаагчдыг чавхжуулах зорилгоор хууль тогтоомжийг шинэчилсэн найруулгуудыг өөрчлөлт орох болон шинэ зүйл заалт бүрээр сургалтыг дотооддоо зохион байгуулж ажиллаж байна.

Монголын бүтээмжийн төв (МБТ) нь Олон Улсын Засгийн газар хоорондын байгууллага болох Азийн Бүтээмжийн Байгууллага /АББ/-д 1992 оноос хойш Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, аж ахуйн нэгжийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор АББ болон бусад гишүүн орнуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гишүүн орнуудад зохион байгуулагдах сургалтад Монгол Улсаас төлөөлөгч хамруулах, АББ-ын сургалт, арга хэмжээг өөрийн оронд жил бүр зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Энэ үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс МБТ-тэй 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 09/23 тоот Хамтран ажиллах гэрээний дагуу Монгол улсын засгийн газрын 265 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан Монголын бүтээмжийн төвтэй хамтран шат дараалсан бүтээмж дээшлүүлэх, чанар сайжруулах сургалтуудыг зохион байгуулж ажиллаж.

2023 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр Төрийн байгууллагын бүтээмжийг тухай ойлголт сургалтыг Монголын бүтээмжийн төлийн сургагч багш нар ирж бүтээмжийг хэрхэн дээшлүүлэх төрийн байгууллагад бүтээмжийг хэрхэн үр ашигтай тасралтгүй хөгжүүлэх талаар сургалт зөвлөгөөний зохион байгуулж ажиллалаа.



ТАВ. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны “Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай” А/01 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хотоо угаая” аяны хүрээнд иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Их цэвэрлэгээ 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2023 оны 05 дугаар сарын 26-ний өдрийн 11:00-12:30 цагийн хооронд зохион байгуулж, хэлтсийн өөрийн байр болон Хайлааст дахь тасгийн байрны ойр орчмын 50 м хүртэлх талбайг цэвэрлэн, угааж, хог хаягдлыг түүж, хогийн цэг рүү ачуулж, ажиллалаа.



Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 81 жилийн ойн тохиолдуулан 2023 оны 05 сарын 10-15-ний өдөр нийслэлийн нийгмийн даатгалын байгууллагуудын дунд зохион байгуулагдсан 6 төрөлт спортын тэмцээнд тус хэлтэс амжилттай оролцож, е-спортын төрөлд хүрэл медаль, эмэгтэй гар бөмбөгийн төрөлд мөнгөн медаль тус тус хүртсэн.



2023 оны 05 дугаар сарын 13-ний өдөр "Сая модтой Чингэлтэй" аянд нэгдэж, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчид дөрвөн төрлийн 100 мод тарьсан.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд тус хэлтсийн хамт олон гурав дах жилдээ нэгдэж 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хайрхан хөгжлийн төв”-ийн орчимд 50 ширхэг гацуур мод тарьж “Чингэлтэй дүүргийн Нийгмийн Даатгалын Хэлтсийн нэрэмжит төгөл-ийг бий болголоо.



Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны “Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай” А/01 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд

амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, халтирч унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Их цэвэрлэгээ 90 минут” бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай удирдамжийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, 2-21,3-24,4-21,5-12,6-05,10-24,10-30-ны өдрүүдэд бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, хэлтсийн өөрийн байр болон Хайлааст дахь тасгийн байрны ойр орчмын 50 м хүртэлх талбайг цэвэрлэн, цас мөсийг арилган, хальтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэн, хог хаягдлыг түүж, хогийн цэг рүү ачуулж, ажиллалаа.



Хэлтсийн гадна ойр орчмын 50м хүртлэх явган хүний зам талбайг цэвэрлэж иргэдийн ая тухтай таатай орчинд үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж цэвэрлэгээ үйлчилгээг хийлээ.



Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафон-2023” олон улсын гүйлт тавдугаар сарын 28-ний өдөр Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж тус хэлтсийн албан хаагчид “Улаанбаатар марафон” аянд нэгдэж, идэвхтэй оролцсон.




Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн авьяас чадварыг түгээх, урамшуулах, соён гэгээрүүлэх, хүүхдэд ээлтэй хамт олныг бий болгох, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 01 сарын 28-ний өдрийн А/07 тоот тушаалаар Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан Эцэг эхийн зөвлөлийн дүрмийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Тус хэлтсийн дэргэдэх Эцэг эхийн зөвлөл нь 2023 онд албан хаагчдад чиглэсэн олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд үйл ажиллагааны тайлан, судалгааг дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтсийн ажилтан, албан хаагчдын хүүхдүүд тус хэлтсийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, хэлтсийн дэргэдэх “Эцэг эхийг зөвлөл”-өс санаачлан Хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгууллаа.

Хэлтсийн нийт албан хаагчдад төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлэх, хэвшил болгох, календарь гаргах: Хэлтсийн давхар бүрд хэлтсийн албан хаагчдын төрсөн өдөр, нийтээр амрах тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэсэн календарь хэвлүүлж байршуулсан. Мөн албан хаагчдын төрсөн өдрийг хэлтсийн албан хаагчдын цахим хуудас (чдндх хамт олон) хаягаар дамжуулан мэндчилгээ дэвшүүлж байна.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачилсан, Чингэлтэй дүүргийн Агаарын бохирдолтой тэмцэх тасаг хамтран зохион байгуулсан “Өгөөмөр өдөр” арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 07 -ний өдөр зохион байгуулж тус хэлтэс оролцож дахин ашиглагдах зүйлсээ бусдад хандивлах аянд нэгдэн оролцлоо.


Тус арга хэмжээний зорилго нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж бууруулах, дахин ашиглах чиглэлээр иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх, хэрэггүй болсон эд зүйлсээ хог хаягдал болохоос сэргийлж хэрэгцээтэй хэн нэгэнд хандивлах юм. “Өгөөмөр өдөр” арга хэмжээг санаачилсан болон зохион байгуулсан мөн идэвхтэй оролцсон зохион байгуулагдлаа.






Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын нэрэмжит туг аялуулах аяны хүрээнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих, хамгааллыг сайжруулах, бүтээлч идэвх саначилгыг түгээн дэлгэрүүлэх зоригор тус хэлтэс нь иргэд даатгуулагчид орох гарах гарц болон гадаа үүдний хөндлөн гарц зэргийг стандартын дагуу хийж, тулгуур эрхтэний хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн даатгалын үйлчилгээ авахаар ирэхдээ туслаж дуудах хонх шинээр байршуулсан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагч нарт Нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор дараалал харгалзахгүй чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. "Ухаалаг ажлын байр" төслөөр дамжуулан иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг нэг цэг дээрээс хүлээн авах боломж бүрдсэн. Ингэснээс иргэд даатгуулагчид ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2-3 давхарлуу шатаар өгсөх, олон өрөө хэсэх шаардлагагүй болж, нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шинэлэг хэлбэрээр хүргэн ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан чиглүүлэх зорилгоор "Дуугүй хөтөч" буюу орох гарах чиг заасан таних тэмдэг, бусад чиглүүлэх хөтөчүүдийг байршуулан мэдээлэл хүргэж байна.



Тус хэлтэс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор Хөтөч байцаагчийг тогтмол ажиллуулж, иргэд даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.



Иргэд даатгуулагчид ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн даатгалын ажил үйлчилгээ авах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн нэг давхрын ариун цэврийн өрөөнд засвар тохижилтын ажлуудыг хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул түшлэгийг шинээр хийж гүйцэтгэсэн.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар:

Хувиар хөдөлмөр эрхлэгч иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сайн дурын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, бусад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулсан.



Хэлтсийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэрлэлийг дэмжих, жижиг дунд үйлдвэрлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах, 2023 оны байдлаар нийт 16 удаа шууд Live хийж, 16560 гаруй иргэд даатгуулагчид үзсэн хандалттай байна.

Тус хэлтэс нь Дэлхийн Монголчуудын Радио 88.3-тай хамтран шууд эфирт оролцон утсаар 2 удаа нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлуудыг тогтмол зохион байгуулан ажилласан. Хэлтсийн сургалт болон дотоод ажлын төлөвлөгөөнд заасны дагуу нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэн даатгуулагчдад үйлчилгээг үзүүлж хамралтыг нэмэгдүүлж байна. Энэ ажлын хүрээнд Бөмбөгөр худалдааны төв, Хүчит шонхор, Нарантуул-2, Нарлаг дэнж худалдааны төв, Тэди худалдааны төв, Сүхбаатарын талбайд 3 удаа, Тусгаар тогтнолын талбайд 3 удаа үйлчилгээ үзүүлж, нийт 1250 гаруй иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Хороодтой хамтран 2 удаа аян зохион байгуулж, дүүргийн бусад хэлтэс албадтай 6 удаа хамтран оролцоог ханган ажиллаж байна.

Монголын бүтээмжийн төв (МБТ) нь Олон Улсын Засгийн газар хоорондын байгууллага болох Азийн Бүтээмжийн Байгууллага /АББ/-д 1992 оноос хойш Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, аж ахуйн нэгжийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор АББ болон бусад гишүүн орнуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гишүүн орнуудад зохион байгуулагдах сургалтад Монгол Улсаас төлөөлөгч хамруулах, АББ-ын сургалт, арга хэмжээг өөрийн оронд жил бүр зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Энэ үйл ажиллагааны хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс МБТ-тэй 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 09/23 тоот Хамтран ажиллах гэрээний дагуу Монгол улсын засгийн газрын 265 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаатай холбогдуулан Монголын бүтээмжийн төвтэй хамтран шат дараалсан бүтээмж дээшлүүлэх, чанар сайжруулах сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгэмд чиглэсэн бизнес эрхлэлт” сэдэвт семинарт Орлого шимтгэлийн тасгийн дарга М.Отгонцэцэг оролцож байгаа бөгөөд уг семинар нь онол, практик хосолсон арга хэмжээ бөгөөд Олон улсын тэргүүн туршлагаас суралцаж хэлтэсдээ хэрэгжүүлэх мэдлэг ур чадвар хуримтлуулж сайжруулалтын ажлыг хамтран ажиллаж байна. Монголын бүтээмжийн төв нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн сургалт семинарыг тогтмол зохион байгуулж хамтран ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА

Н. АРИУНАА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН

Н.ҮҮРЦАЙХ